

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ,
СУМДЫН 2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2023.08.03

Сүхбаатар сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хурал 7 дугаар сард 2 удаа хуралдаж 19 асуудал хэлэлцлээ.

2023.07.05-ны өдрийн хуралдаанаар:

-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 16 дугаар хуралдааны товыг 2023.07.26-ны өдөр хуралдахаар тогтлоо.

-Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөний биелэлтийг танилцуулж Хангалттай гэж дүгнэлээ.

-Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын мэдээллийг сонсож цаашид анхаарах асуудлын талаар үүрэг чиглэл өглөө.

-Аймгийн ИТХ-аас 2023 онд ойгоос бэлтгэх модны эхний хагас жилийн гүйцэтгэлийн талаарх явц байдлын талаарх аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн албаны даргын мэдээллийг сонслоо.

-Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны тайланг сонсож үнэлэлт дүгнэлт өгч цаашид анхаарах асуудлаар чиглэл өглөө.

-Сэлэнгэ аймгийн “Хүндэт иргэн”-р 3 иргэнийг өргөмжлөх асуудлыг танилцуулан шийдвэрлэлээ.

2023.07.19-ны өдрийн хуралдаанаар:

Аймгийн ИТХ-ын 16 дугаар хуралдаанаар хэлэлцэх 13 асуудлуудыг хэлэлцэн хуралдаанд өргөн барилаа.

Аймгийн ИТХ-ын хуралдаан:

Аймгийн ИТХ-ын 16 дугаар хуралдаан 2023.07.26-ны өдөр хуралдаж дараах асуудлыг хэлэлцлээ. Үүнд:

-2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай

-2023 оны төсөвт тодотгол хийх тухай

-Сүрьеэгүй Сэлэнгэ-2 арга хэмжээ батлах тухай

-Аймгийн төвийн газар доорх инженерийн шугам сүлжээ, байгууламжуудын өнөөгийн байдал, цаашдын төлөвлөлтийн талаарх мэдээлэл

-Сэлэнгэ орон сууц ОНӨААТҮГ, Гавшгай ус ОНӨААТҮГ, Цэнгэг ус ОНӨААТҮГ-дын тайлан сонсох тухай

-Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

-Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах тухай

-Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох, худалдах хөрөнгийн доод үнийг тогтоох тухай

-Сүхбаатар сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай

-Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийн тухай

-Аймгийн Сонгуулийн хороог татан буулгах тухай

-Тогтоол хүчингүй болгох тухай

-Зүүнбүрэн сумын 100 жил, Зүүнбүрэн сумын ЕБС-ийн 100 жил, Түшиг, Ерөө сумын 100 жилийн ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай

-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тавьсан саналын тухай зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Сургалт, мэдээллийн талаар

БНСУ-ын Чүнчонбүг аймгийн багш нар манай аймгийн байгалийн ухааны чиглэлээр хичээл зааж буй багш нарт сургалтын арга туршлагаасаа хуваалцаж 4 өдрийн сургалтыг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Аймгийн төв Сүхбаатар сумын 4 дүгээр багт 600 айлын 9 давхар 14 орон сууц баригдах болсонтой холбогдуулан үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Тус төсөл нь төрийн албан хаагчдыг дэмжих бодлого барьж байгаа бөгөөд “Алсын хараа 2050 - Шинэ сэргэлтийн бодлого”, “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийн бодлогын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Сүхбаатар сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ юм. “Арвин алтан бумба” ХХК-ийн гүйцэтгэх “Сэлэнгэ мөрөн” хотхоны шав тавих ёслолын арга хэмжээ 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр бөгөөд эхний ээлжийг 2024 оны 2 дугаар улиралд ашиглалтад оруулахаар ажлаа эхлүүлээ.

Наадмын баярын хурлыг 7 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж салбартаа олон жил хичээл зүтгэл гарган, хөдөлмөр бүтээлээ үнэлүүлж төрийн дээд одон медалиар шагнуулсан Сэлэнгэ аймгийн харьяат иргэд болон аймгийн “Хүндэт иргэн”-ээр өргөмжлөгдсөн иргэдэд хүндэтгэл үзүүллээ. Тус баярын хурлаар Сэлэнгэ аймгийн хүндэт иргэнээр өргөмжлөгдсөн 3, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнагдсан 9, Алтангадас одонгоор шагнагдсан 21, Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдсан 6, Салбарын шагналаар шагнагдсан 14, Аймгийн хүндэт тэмдгээр шагнагдсан 6, Аймгийн жуух бичгээр шагнагдсан 12 иргэд шагнагдлаа.

Баяр наадмын үеэр Цагааннуур сумын “Нарийн Шүрэн” ХХК-ийн зөвлөх инженер Нацагийн Дэлгэрмөрөн Хөдөлмөрийн баатар, Мото спортын тамирчин Эрдэнэбилэгийн Халиунболд Монгол Улсын Гавьяат тамирчин, Оюун ухааны спортын дасгалжуулагч “Оюун ухааны академи”-ийн захирал Хандсүрэнгийн Хатанбаатар Монгол Улсын Гавьяат багшаар тус тус шагнагдлаа.

7 дугаар сарын 10,11-ны өдрүүдэд Тулгар төрийн 2232, Их Монгол Улсын 817, Ардын хувьсгалын 102, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 92 жилийн ойн баяр наадам аймаг, болон сумдын хэмжээнд зохион байгуулагдлаа.

Тус зөвлөлөөс 7-р сарын 19-ний өдөр зохион байгуулахаар зарласан Дэс түшмэлийн 25 албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 54-р тоот тогтоолоор томилогдсон шалгалтын комисс тогтоосон хугацаанд зохион байгууллаа.

Шалгалтад нийт 15 оролцогч оролцож, 11 сул орон тоог нөхөх арга хэмжээ авлаа.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:

Гамшиг ослын дуудлагын талаар

Тайлангийн хугацаанд объектын гал түймрийн 4, авто осол 1, усны осол 2, үерийн 46, голын усанд боогдсон 2, нийт 55 удаагийн гамшиг осол, гал түймрийн дуудлагаар гарч иргэн, аж, ахуйн нэгж байгууллагын өмч хөрөнгийг гал түймэр, гамшиг ослын аюулаас авран хамгаалж, гол мөрний усанд осолдсон 2 буцалтгүй нэрвэгдэгчийг цагдаагийн байгууллага болон ар гэрт хүлээлгэн өгч ажилласан.

7 дугаар сарын 5-10-ны өдрүүдэд 8 сум, 2 тосгон үер, усны эрсдэлтэй нөхцөл байдалтай байсан. Байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон Мандал, Баянгол, Ерөө, Сайхан, Хүдэр, Сүхбаатар, Шаамар, Жавхлант, Зүүнбүрэн сумд Бугант, Дулаанхаан тосгодод Онцгой байдлын газар, Цагдаа, Сумын онцгой комисс, ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах сайн дурын бүлгүүд, ард иргэдийн тусламжтайгаар аж ахуйн нэгж байгууллага 3, 194 айл өрх,

979 иргэн, 176 гэр, 750 гаруй малыг үерийн уснаас нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

Мандал суманд болсон байгалийн гамшиг үерийн аюулд өртсөн айл өрхийг аврах ажиллагаанд дайчлагдан 14 айл өрхийн орон гэр, эд хөрөнгө, 30 иргэний амь насыг аварч иргэний үүргээ нэр төртэй биелүүлж явахдаа иргэн Л.Даваажаргал өөрийн амь эрсэдсэн харамсалтай явдал болсон.

Мөн Мандал суманд байрлах Хараа голын үндсэн гүүр үерийн улмаас 7 дугаар сарын 8-ны өдөр 2 үе хавтан нурсныг засварлах асуудлыг Засгийн газарт уламжилсны дагуу Засгийн газрын хуралдаанаар 1,5 тэрбум төгрөг, Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын XVI хуралдаанаар 2023 оны төсөвт тодотгол хийж 300.0 сая төгрөгийн хөрөнгийг тус тус шийдвэрлэлээ.

Урьдчилан сэргийлэх чиглэлээр

“Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-ийн хүрээнд иргэдийн аюулгүй байдлыг хангах, үер, усны ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Онцгой байдлын газрын Баянгол, Сайхан, Сүхбаатар, Хүдэр суман дахь Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх, аврах анги, салбарын алба хаагчид голын эрэг дагуу амарч, зугаалж байгаа иргэдэд үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг 5100 иргэнд өгч, 3500 ш сэрэмжлүүлэг мэдээлэл тараан ажилласан.

Онцгой байдлын газрын Мандал сум дахь Гал түймэр унтраах, аврах 19, Хүдэр сум дахь Эрэн хайх, аврах салбарын алба хаагчид тус суманд иргэд ихээр цуглардаг голын эрэг дагуу урьдчилан сэргийлэх 14 ширхэг самбарыг байршуулсан.

Аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн гол мөрний усны түвшний талаар мэдээлэл авч, сэрэмжлүүлгийн хамт байгууллагын цахим хуудсанд байршуулж, 17 сум, 6 тосгоны цахим хуудсанд түгээж, нийт 16,000 хандалт авч урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэсэн.

Сэлэнгэ аймгийн 92 жилийн ойн баяр наадмын хүрээнд олон нийтийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, баяр наадам зохион байгуулагдах талбайд Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангаж, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн нийт 21 аж ахуй нэгж, иргэнд гал түймрийн улсын хяналтын байцаагчийн албан мэдэгдэл хүргүүлэн 17 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулан ажилласан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан “Иргэн хуулийн этгээдийн шатахуун түгээх станц”-д Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, нормативын баримтын бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналтын шалгалтын удирдамжаар Сүхбаатар, Баянгол, Мандал сумдад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2023 оны 07 дугаар сарын 1-ний өдрөөс 07 дугаар сарын 26-ны өдрүүдэд зохион байгуулан ажиллалаа.

Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан Сүхбаатар, Баянгол, Мандал, Сайхан зэрэг сумдад үйл ажиллагаа явуулж буй 13 аж ахуйн нэгж байгууллагын 15 объектод зохион байгуулж 75 зөрчил илрүүлж, 7 зөрчлийг газар дээр нь арилгуулан, бусад зөрчлийг арилгуулахаар гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 15-ыг хүргүүлсэн.

Ажлын байрны дүгнэлт олгосон байдал

Тайлант үед 10 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж зөрчлийг арилгасан 10 объектод ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт олгосон.

Барилга байгууламжийн зураг төсөл хянасан байдал.

Төрийн болон аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн барилга байгууламжийн 8 ажлын зургийг хянаж Онцгой байдлын газрын даргаар баталгаажуулан дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Эрсдэлийн удирдлага, үнэлгээний талаар

Онцгой байдлын ерөнхий газрын “Үерийн эрсдэлийн үнэлгээ хийх тухай” албан бичгийг хэрэгжүүлэн аймгийн үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг 17 сумын хэмжээнд холбогдох албан тушаалтнуудыг байлцуулан, чиглэл бүхий мэдээ, мэдээлэлд тулгуурлан хийж гүйцэтгэлээ.

Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ын дагуу үерийн эрсдэлийн тодорхойлох индексийн аргаар тодорхойлсон.

Үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний үр дүн

№	Аюул	Өртөх байдал	Эмзэг байдал	Чадавх	Эрсдэлийн индекс
Сэлэнгэ аймаг	2.4	1.8	2.8	2	5

Сэлэнгэ аймгийн хэмжээнд хийсэн үерийн эрсдэлийн үнэлгээгээр 47.14 хувь буюу **дунд** түвшний эрсдэлтэй. Сүхбаатар сумын эрсдэлийн түвшин **өндөр**, Алтанбулаг, Баянгол, Баруунбүрэн, Ерөө, Жавхлант, Зүүнбүрэн, Мандал Орхон, Орхонтуул, Сант, Сайхан, Хушаат, Хүдэр, Түшиг, Цагааннуур, Шаамар сумдын эрсдэлийн түвшин **дунд** дүгнэгдсэн.

Улсын Онцгой комиссын 2023 оны 44 дүгээр үүргийн 5.3 дахь заалт “Зуншлага тааруу байгаа аймгууд гангийн эрсдэлийн үнэлгээг Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан ган, зудын эрсдэлийн үнэлгээ хийх зааврын дагуу гаргасан.

Аймгийн зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээг 17 сумын хэмжээнд Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаал “Гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар”-ын хавсралтаар батлагдсан дагуу зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийсэн.

Зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээний үр дүн

№	Аюул	Өртөх, эмзэг байдал	Чадавх	Эрсдэлийн индекс
Сэлэнгэ аймаг	4.7	4.9	5	4.71

Аймгийн Засаг даргын 2023 оны А/412 дугаар захирамжийн хүрээнд аймгийн 17 сумын хэмжээнд индикаторын аргачлал ашиглан нийт сумдын гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

№	Сумдын нэрс	Аюул	Өртөх, эмзэг байдал	Чадавх	Эрсдэл
1	Алтанбулаг сум	5.8	5.2	4.7	6.4
2	Баянгол сум	4.3	5.2	4.7	4.8
3	Баруунбүрэн сум	4.8	6.4	4.7	6.5
4	Ерөө сум	5.8	4.6	5.2	5.1
5	Жавхлант сум	5	5.2	5	5.2
6	Зүүнбүрэн сум	4.3	4	5	3.4
7	Мандал сум	4	6	5.3	4.5

8	Орхон сум	4.5	4.6	5.2	4.0
9	Орхонтуул сум	4.3	6	5	5.2
10	Сант сум	4.5	4	4.3	4.2
11	Сайхан сум	4.3	6	5	5.2
12	Сүхбаатар сум	5.8	4.6	5	5.3
13	Хушаат сум	5	5.2	6.3	4.1
14	Хүдэр сум	4	3.4	6.8	2.0
15	Түшиг сум	4.3	4.6	4.3	4.6
16	Цагааннуур сум	4.3	5	5	4.3
17	Шаамар сум	6	5	5	6.0
Сэлэнгэ аймаг		4.7	4.9	5	4.71

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

7 сард 822 баримтаар 18,5 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн вэб сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулан ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг сум бүрд хуваарилан тавьж, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт олгосон.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		55,803,736.3	54,373,560.1	629.4
1	Орон нутгийн төсвийн орлого	28,245,038.2	28,698,332.7	101.6
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	12,265,934.2	5,614,100.2	45.8
	Сумдын төсвийн орлого	15,979,104.0	23,084,232.5	144.5
2	Сумдаас авах орлогын шилжүүлэг	2,491,720.9	2,491,720.9	100.0
3	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	10,084,028.0	10,084,028.0	100.0
4	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	3,404,314.3	3,404,314.3	100.0
5	Хандив /Орон нутгийн хөгжлийн сан/	600,000.0	-	-
6	Төсөвт байгууллагын өөрийн орлого	846,259.4	694,587.3	82.1
7	Сум хөгжүүлэх сангийн орлого	1,720,849.2	836,749.6	48.6
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		55,803,736.3	32,975,260.0	59.1
1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	55,803,736.3	32,975,260.0	59.1
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	31,018,917.8	21,393,325.1	69.0
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	9,203,932.6	2,840,365.2	30.9
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	15,580,885.9	8,741,569.7	56.1
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	3,252,651.7	729,886.5	
	Аймгийн орон нутгийн	5,007,323.8	712,446.8	14.2

	хөгжлийн сан			
	Халамжийн сан	94,824.0	63,019.0	66.5
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	6,426,086.4	6,571,432.7	102.3
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	800,000.0	664,784.7	83.1
	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	-	-	-
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		28,128,687.4	10,073,227.0	100.0
1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	4,065,596.3	4,065,596.3	100.0
2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	16,098,217.2	4,474,213.9	-
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	151,999.8	25,333.3	-
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	-
	Хөрөнгө оруулалтын зардалд	15,946,217.4	4,448,880.6	-
3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	7,964,873.9	1,533,416.8	-
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	7,736,323.7	1,400,733.2	-
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	198,550.2	117,683.6	-
	Усан хангамжийн татаас	30,000.0	15,000.0	-
4. Тусгай сангуудын зарлага		1,720,849.2	836,749.6	48.6
1	Сумдын сум хөгжүүлэх сан	1,720,849.2	836,749.6	48.6

2.Өргөн хэрэглээний барааны үнэ:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2022–VI	2023 – VI	2023 - VI/2022 - VI
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	Талх, гурил, будаа	1 500	2 200	146.7
	Гурил /Алтантараи, I зэрэг, кг/	1 500	2 200	146.7
	Талх /орон нутгийн, ш/	1 400	1 900	135.7
	Нарийн боов /кг/	3 500	5 000	142.9
	Будаа /кг/	3 200	3 700	115.6
	Элсэн чихэр /кг/	3 200	3 700	115.6
2	МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	10 000	13 700	137.0
	Үхрийн мах /кг/	13 500	15 500	114.8
	Адууны мах /кг/	9 500	10 900	114.7
	Ямааны мах /кг/	9 500	11 700	123.2
	Дотор мах, цувдай /цусгүй/	4 000	8 000	2.0
	Хиам /чанасан, кг/	15 800	16 500	104.4
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1 700	2 500	147.1
	Сүү / савласан, л/	4 500	4 700	104.4

	Тараг /задгай, л/	2 600	2 900	111.5
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	25 000	24 800	99.2
	Айраг /л/	5 000		
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	6 000	8 200	136.7
	Өндөг /ш/	450	450	100.0
4	Бүх төрлийн өөх тос			
	Ургамлын тос /л/	8 600	10 800	125.6
	Өөхөн тос /кг/	2 500	3 700	148.0
	Шар тос /кг/	25 000	29 100	116.4
	Масло /задгай, кг/	6 500	10 900	167.7
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 500	1 700	113.3
	Лууван /кг/	3 500	2 000	57.1
	Манжин /кг/	3 500	3 500	100.0
	Байцаа /кг/	3 500	2 300	65.7
	Сонгино /кг/	3 200	3 500	109.4
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	7 600	7 900	103.9
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630 гр/	4 400	5 800	131.8
2. ШАТАХУУН				
1	Бензин А - 80	2 450	2 480	101.2
	Бензин А - 92	2 500	2 500	100.0
	Дизелийн түлш	3 380	3 550	105.0

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Аймгийн Цагдаагийн газар: 2023 оны 07 дугаар сарын байдлаар нийт 410 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 69 (14.4%)-аар буурсан байна. Нийт 32426 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 15100 (87.1%)-аар өссөн байна. Нийт 3600 гомдол мэдээлэл бүртгэгдсэнээс 1084 нь гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл, 2513 нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна.

Аймгийн Шүүх шинжилгээний хэлтэс: 2023 оны 07 дугаар сард шүүх эмнэлгийн шинжилгээний тоо 55, хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоо 41, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр эд мөрийн баримтын тоо 21, гэрэл зургийн ажлын тоо 550, криминалистикийн шинжилгээ 14, цогцост хийсэн шинжилгээний тоо 10-г хийж ажилласан.

Улсын бүртгэлийн хэлтэс:

2023 оны 07 дугаар сарын иргэний бүртгэлийн талаар:

- Төрсний бүртгэл - 121 /эрэгтэй-74, эмэгтэй-44/
- Гэрлэлтийн бүртгэл - 28
- Гэрлэлт цуцалсны бүртгэл - 6
- Үрчлэлт - 5
- Эцэг, эх тогтоолт – 4 /үүнээс эрэгтэй 3, эмэгтэй 1/
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 6
- Нас баралт - 47
- Нийт олгосон иргэний үнэмлэх - 266
- Шинээр олгосон иргэний үнэмлэх - 96
- Дахин олгосон иргэний үнэмлэх - 24
- Иргэний үнэмлэхийн хугацаа дуусаж авсан - 146
- Гадаад паспорт олголт - 391

- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн – 87 /үүнээс насанд хүрсэн 60, хүүхэд 26/
- Хот доторх шилжилт хөдөлгөөн - 66 тус тус бүртгэгдсэн байна.

Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн талаар:

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо - 526
- Анхны бүртгэл - 160
- Өмчлөх эрх шилжих гэрээ - 120
- Барьцааны гэрээ - 204
- Бүртгэлд өөрчлөлт оруулах - 18
- Лавлагаа хуулбар - 9
- Нийт бичигдсэн гэрчилгээний тоо – 297

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, өмчлөх эрхийн улсын бүртгэлийн талаар:

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо- 486
- Анхны бүртгэл- 20
- Өмчлөх эрх шилжих гэрээ-60
- Барьцааны гэрээ- 372
- Бүртгэлд өөрчлөлт оруулах- 17
- Лавлагаа хуулбар-5
- Нийт бичигдсэн гэрчилгээ-96

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

Боловсролын чиглэлээр:

Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2023 оны эхний хагас жилийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг нэгтгэн, холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлээ.

7 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд БНСУ-ын Чүнчонбүг аймгийн Чонжү хотын шинжлэх ухааны багш нарын нийгэмлэг, Сэлэнгэ аймгийн ИТХурал, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуультай хамтран байгалийн шинжлэх ухааны багш нарт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад 48 багш хамрагдаж, туршилтад хичээл явуулах заах арга зүй, ур чадвараа хөгжүүлж туршлага солилцож ажилсан.

7 дугаар сарын 28-наас 8 дугаар сарын 02-ныг хүртэл “Хөх хотын олон улсын залуучуудад ээлтэй солилцооны хөтөлбөр”-т хамруулах 2 багш, 8 сурагчийг хамруулахаар болсон

Эрүүл мэндийн чиглэлээр:

БНСУ-ын Сувилахуйн сургуулийн эмч, багш нар болон баг хамт олон 2023 оны 07 дугаар сарын 18,19-ний өдрүүдэд Мандал болон Сүхбаатар сумдад 2 өдрийн турш хүн амын дунд үзлэг хийж, аймгийн эрүүл мэндийн төвийн сувилагч нарыг чадавхжуулах сургалтыг зохион байгууллаа.

ДЭМБ-аас хөдөөгийн алслагдсан сум, багийн ард иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэхэд онцгойлон анхаарч “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмын хүрээнд 2016 оноос хойш үе шаттайгаар манай аймгийн 17 сум, 6 тосгоны Эрүүл мэндийн төвүүдэд “Мобайл технологи буюу зөөврийн ЭХО аппарат” нийлүүлэх төслийг амжилттай хэрэгжүүлж ажилласан билээ. Уг төсөл орон нутагт хэрхэн үр дүнтэй хэрэгжиж буйд хяналт тавихаар Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол дахь Суурин төлөөлөгч Сокоро Эскланте, тархвар судлаач Жосика Скуфка нар 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдөр манай аймагт ажиллах үеэрээ Жавхлант сумын Эрүүл мэндийн төвийг төлөөлөл болгож газар дээр нь үзэж танилцлаа.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн хамт олон сурфактант эмчилгээгээр нэг нярайн амь нас аварсан.

Тус төрөх тасгийн хамт олон нь 2016 оноос эхлэн сурфактант эмчилгээг орон нутагтаа шинээр нэвтрүүлж амьсгал хямралын хам шинжтэй дутуу төрсөн нийт 21 нярайд тус эмчилгээг хийж байгаа бөгөөд тус хамт олон 2023 оны эхний хагас жилийн байдлаар шинээр мэндэлсэн нэг нярайд энэхүү эмчилгээг хийж амь насыг нь авраад байна. Дутуу төрсөн нярайн хамгийн эрт үеийн хүндрэл буюу төрсний дараа шууд үүсдэг эмгэгийн нэг нь амьсгал хямралын хам шинж илрэх тохиолдол байдаг. Энэ нь амьсгал хямралын хам шинжтэй 35 долоо хоногтойгоос доош тээлтийн хугацаанд төрсөн нярайд амьдралын эхний цагуудад сурфактант эмчилгээ хийгдэхэд эмчилгээний үр дүн нэмэгдэж бага жинтэй нярайн амьдрах чадварыг нэмэгдүүлэх өндөр үр дүнтэй орчин үеийн эмчилгээний арга болоод байгаа. Энэхүү эмчилгээ нь дутуу нярайн олон хүндрэлүүдийг бууруулж, өндөр ур чадвар шаардсан багаар үзүүлдэг тусламж үйлчилгээ юм.

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 05 дугаар сарын 01-ээс хэрэгжүүлж эхэлсэн “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо шинжилгээнд хагас жилийн байдлаар 2585 иргэн хамрагдсан. Үүнээс 0-17 насны хүүхэд 93, 18-30 насны иргэн 233, 31-45 насны хүүхэд 840, 46-60 насны иргэн 1007, 61-ээс дээш насны 412 иргэн тус тус хамрагдсан байна.

Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл мөн Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2-т заасны дагуу “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” ажлын хүрээнд 2023-2026 онд “Сүрьеэгүй Сэлэнгэ 2” арга хэмжээг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 120 тоот тогтоолоор 433,2 сая төгрөгийн төсөвтэй батлууллаа. Дээрх арга хэмжээ нь Хиймэл оюун ухаанд суурилсан дэвшилтэт технологийн тусламжтайгаар 2023-2026 онд дөрвөн зорилтын хүрээнд “Сүрьеэгүй Сэлэнгэ 2” болж үргэлжлэн хэрэгжих юм. Хиймэл оюун ухаанд суурилсан үзлэг оношилгоог эмчилгээ, үйлчилгээнд нэвтрүүлснээр сүрьеэгийн далд халдварыг эрт үед нь оношилж, эмчлэх улмаар өвчлөл, тархалтыг бууруулж, эрсдэлт бүлгийн хавьтлыг бүрэн хянах боломжтой гэж үзэж байна.

Манай аймаг 2017-2020 онд “Сүрьеэгүй Сэлэнгэ” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлснээр аймгийн хүн амын 60 орчим хувийг үзлэг, оношилгоонд хамруулж, 180 шинэ тохиолдлыг эрт үед нь илрүүлж эмчилсэн үзүүлэлттэй байна.

Хөдөлмөр, халамжийн чиглэлээр:

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй чанартай хүргэх ажлын хүрээнд:

Улсын төсвийн орлогоос:

Халамжийн санд улсын төсвөөс тайлант хугацаанд 66681 иргэнд 31,188,082.5 мянган төгрөгийг олгоод байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2327 иргэнд 3,777,965.6 мянган төгрөг
- Нийгмийн халамжийн тэтгэмжид 1778 иргэнд 924,028.3 мянган төгрөг
- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 1651 иргэнд 733,666.1 мянган төгрөг
- Жирэмсэн эхийн тэтгэмжид 727 эхэд 148542.5 мянган төгрөг
- 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 4218 эхэд 1,178,704.8 мянган төгрөг
- Ихэр хүүхдийн тэтгэмжид 8 иргэнд 16,000.0 мянган төгрөг
- Өрх толгойлсон эхийн тэтгэмжид 225 иргэнд 243,972.9 мянган төгрөг
- Ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламжид 2430 ахмадын 204,813.5 мянган төгрөг

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжид 282 иргэний 86,996.8 мянган төгрөг
- Алдар цолтон ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламжид 48 иргэнд 8,028.1 мянган төгрөг
- Насны хишиг тэтгэмжид 5750 иргэнд 889,320.0 мянган төгрөг
- Эхийн алдар одонгийн тэтгэмжид 9332 иргэнд 1,242,300.0 мянган төгрөг
- Хүнсний эрхийн бичгийн 1790 иргэнд 118,144.0 мянган төгрөг
- Хүүхдийн мөнгөн тэтгэмжид 36115 иргэнд 21,615,600.0 мянган төгрөгийг тус тус зарцууллаа.

Орон нутгийн төсвийн орлогоос:

Халамжийн санд орон нутгийн төсвөөс тайлант хугацаанд 299 иргэнд 82,172.0 мянган төгрөгийг олгоод байна. Үүнд:

- Орон гэрийн хөнгөлөлт, тусламжид 21 иргэнд 25,200.0 мянган төгрөг
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 103 иргэнд 50,900.0 мянган
- Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулалд 175 иргэнд 6,072.0 мянган төгрөгийг тус тус зарцууллаа.

Хөдөлмөр эрхлэлт:

Сайхан, Цагааннуур, Орхонтуул, Алтанбулаг, Дулаанхаан, Сүхбаатар, Хүдэр, Орхон, Мандал, Баянгол, Сүхбаатар, Жавхлант, Ерөө сум, Номгон, Хэрх, Түнхэл тосгодод үерийн далан сэргээн засварлах, нийтийн эзэмшлийн талбай цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, хашаажуулалт, зам засвар, баяр наадмын талбайн тохижилт хийх нийтийг хамарсан ажилд 222 иргэн хамрагдаж цалин урамшуулал, ХАБЭА-н зардалд 47,358.0 мянган төгрөг зарцуулж 222 иргэн түр ажлын байраар хангагдлаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны түрээсийн хөнгөлөлтөд Мандал, Сүхбаатар сумын 2 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдаж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 1,732.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосон.

Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагаанд ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ арга хэмжээнд 6 ахмад настан боловсрол, эрүүл мэнд, мал эмнэлэг, төрийн захиргааны салбарт зөвлөх үйлчилгээ үзүүлж 4,680.0 мянган төгрөгийн урамшуулал хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарцуулсан.

Гэр бүл, хүүхэд залуучуудын чиглэлээр:

Гол усны аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор завьт болон явган эргүүлийн үүрэг гүйцэтгэж дараах зөвлөмжийг хүргэсэн. Үүнд:

-Иргэд бага насны хүүхдийг гол усны ойролцоо тоглуулахгүй байх, хүүхдэд тавих хараа, хяналтаа сайжруулах,

-Архи, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ голын усанд орохгүй байх;

-Гол, нуурын эрэг дагуу нутаглаж буй иргэд, малчид, аж ахуйн нэгж байгууллага, аялал зугаалгаар яваа хүмүүс үер, усны аюулаас сэрэмжлэх, гүүр гарамгүй газраар гол, ус гатлахгүй байхыг онцгойлон анхааруулсан.

Үндэсний их баяр наадамд нийт 268 уяач, 1422 хурдан морьд, давхардсан тоогоор 1422 уралдаанч хүүхэд уралдаж, тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг ханган ажиллалаа. Үүнд:

-Хурдан морины уралдаан, уралдаанч хүүхэд, уяачдыг бүртгэлийг цахимжуулах зорилгоор 15 суманд тус бүр 1 ширхэг карт уншигч, 50 ширхэг карт хүргүүлсэн.

-Хурдан морины уралдааны үед уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавигдах шаардлага MNS 6264:2018 стандартын хэрэгжилтийг хангаж, гарааны үед картаар хүүхдийн бүртгэлийг баталгаажуулж, стандартын

шаардлага хангаагүй хувцас хэрэглэлтэй, даатгалд хамрагдаагүй, бүртгэл хийлгээгүй хүүхдийг гараанд гаргахгүй байх, аюулгүй байдалд хяналт тавьсан.

- Шаамар, Сүхбаатар, Алтанбулаг, Баянгол суманд уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг ханган ажилласан.

-Мориноос унасан 14 хүүхдийн 9 нь гэмтэлгүй, 2 хүүхдэд эмнэлгийн тусламж үзүүлж, эцэг эх, асран хамгаалагч, уяачдад хүлээлгэн өгсөн.

-Эцэг эх, асран хамгаалагч, уяачдад 850 ширхэг гарын авлагыг тарааж, мэдээллээр хангасан.

Биеийн тамир, спортын чиглэлээр:

Сэлэнгэ бодонгууд клубийн нэрэмжит сагсан бөмбөгийн 3x3 аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг нээлттэй явуулж, тэмцээнд эрэгтэй 26 баг эмэгтэй 7 багийн 136 тамирчин оролцсон.

Тулгар төрийн 2232 жил, Их монгол улсын 817 жил, Ардын хувьсгалын 102 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 92 жилийн түүхт их ойн баяр наадмын Үндэсний бөхийн барилдаанд 128 бөхчүүд барилдаж Аймгийн заан Б.Ганбаяр түрүүлж Аймгийн арслан цол хүртэж сумын заан Б.Алтанбаяр үзүүрлэн Аймгийн заан цол хүртэн шинээр шөвгийн 4 үлдэн сумын начин Ш.Энхбаясгалан аймгийн начин цол хүртсэн бол үндэсний гурван сурын харваанд нийт 245 харваачид өрсөлдөж аймгийн мэргэн цолтой харваачид 2 нэмэгдлээ.

Соёл урлагийн чиглэлээр:

Үндэсний их баяр наадмын соёл, урлагийн үйл ажиллагаанд нийт 600 гаруй Сэлэнгэ нутгаас төрөн гарсан алдартан гавьяатнууд, төвийн урлагийн байгууллагуудын болон Ардын, дуу бүжгийн "Сэлэнгийн долгио" чуулгын уран бүтээлчид, чөлөөт уран бүтээлчид, соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчид, төрийн албан хаагчид, хүүхэд, багачуудыг хамруулан ажилласан.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:

Хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд: 2023 оны аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 17,0 тэрбум төгрөгийн 134 төсөл, арга хэмжээ төлөвлөж, 85 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас 82 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 82 дугаар тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалтын ажлуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 46 аж ахуйн нэгжтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байгаа ба аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7 төсөл арга хэмжээний 388.8 сая төгрөгийн, их засварын эх үүсвэрээр 8 төсөл арга хэмжээний 787.9 сая төгрөгийн, замын сангийн эх үүсвэрээр 2 төсөл арга хэмжээний 89,2 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 18 төсөл арга хэмжээний 2,243.3 сая төгрөг буюу нийт 35 төсөл арга хэмжээний 3,509.2 сая төгрөгийг аж ахуйн нэгжид гүйцэтгэлээр санхүүжилтийг олгосон.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Засгийн газрын тогтоолоор аймгийн Засаг даргад эрх шилжсэн 17 төсөл арга хэмжээний 7.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгуулахаар "pimis.publicinvestment.gov.mn" цахим хаягт гэрээг баталгаажуулан, гүйцэтгэлийн санхүүжилтийн материалыг хянан баталгаажуулж, санхүүжилтийг олгуулан ажилласан.

Хөрөнгө оруулалтын ажлуудын худалдан авах ажиллагаа, гүйцэтгэгч аж ахуй нэгж болон санхүүжилтийн талаарх мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр Засгийн газрын "www.shilen.gov.mn" болон аймгийн "www.selenge.gov.mn"-д цахим хуудас байршуулан ажиллаж байна.

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр: Аймгийн хэмжээнд 305.5 мянган га тариалангийн эргэлтийн талбайтай, үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг 278 аж ахуйн нэгж, 161 иргэн, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхэлдэг 33 аж ахуйн нэгж, 2118 иргэн, жимс жимсгэнэ тариалдаг 5 аж ахуйн нэгж, 475 иргэн 207.0 мянган га

талбайд тариалалт хийснээс улаанбуудай 127,0 мянган га, арвай 919 га, овьёос 3729 га, гурвалжин будаа 559 га, тэжээлийн ургамал 19.1 мянган га, тосны ургамал 48,7 мянган га, төмс 2375 га, хүнсний ногоо 4145 га талбайд тариалж, 97,5 мянган га талбайд химийн болон механик уринш боловсруулалт хийсэн.

Улаанбуудай тариалсан 127,0 мянган га талбайд тариалалтын чанарын соёололтын үзлэгийг зохион байгуулахад 53,3 хувь нь онц, 41,1 хувь нь сайн, 5,6 хувь нь дунд дүнтэй гарч, Мандал, Ерөө, Сайхан, Баянгол, Хушаат сумдын 5 аж ахуй нэгж, 64 иргэний нийт 1314,2 га талбай мөндөр болон үер усны аюулд өртсөнөөс 700 га улаанбуудайн талбай мөндөрт цохиулж 240 га, 334,2 га талбайн төмс, хүнсний ногоо, 40 га эрдэнэ шишийн талбай тус тус үерт автаад байна.

Засгийн газрын 2020 оны 136 дугаар тогтоолоор үр тариа, тэжээл, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэл хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор ажлын хэсэг байгуулж, шинээр тариалангийн газар эзэмшүүлэх, ашиглаж байгаа тариалангийн талбай хоорондын зайд тэлэлт хийж өргөтгөх, тариалан эрхлэх газарт иргэдэд зөвхөн үр тариа, тэжээл, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тарих зориулалтаар талбай олгох, цаашид зориулалтыг өөрчлөхгүйгээр тариалах талбайг нэмэгдүүлэх боломжийг судалснаар: 11914 га талбай буюу 9 хувь, 700 га талбай буюу 29.5 хувь, 720.6 га талбай буюу 20 хувь нэмэгдэж байна.

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны “Судалгаа хөгжлийн төв”-тэй хамтран “Хөдөө аж ахуйн зохистой дадлагын сургалт”-ыг Мандал, Шаамар, Сүхбаатар сумдын 286 тариаланч ногоочдод, “Зөгийн аж ахуй эрхлэгчдийн дунд зөгийн балын мөшгөх системийг нэвтрүүлэх сургалт”-ыг Шаамар суманд зохион байгуулж, зөгийн аж ахуй эрхлэгчдэд цахим систем нэвтрүүлэх гар утасны аппликэйшныг Зүүнбүрэн, Шаамар сумдын 50 гаруй зөгийн аж ахуй эрхлэгчдэд нэвтрүүлсэн.

Ургац хураалтын ажлыг технологийн хугацаанд гүйцэтгэх зорилгоор Орхон сумын Бэлэндалай баг Мангиртаас Сайхан сумын цементийн үйлдвэр хүртэлх 20 км зам, Орхон сумаас Орхонтуул хүртэлх замын нүхэн гүүрний 3 км, Орхонтуулын Рашаант хуучин төв хүртэлх зам, Хүдэр сумын Хазайн модон гүүр, Дунд гуутын гүүрийг шинээр барих /хуучин гүүр нь нурсан/, Хустайн даваанаас Жаргалантын адаг хүртэлх зам, Улаанбаатар Сэлэнгэ чиглэлийн олон улсын авто замаас Шаамар, Зүүнбүрэн, Түшиг чиглэлийн 120 км авто зам, Баруунбүрэн сумын жүүвчийн голын гүүрний 2 тал, өлийн давааны 10 км замын засвар, доод Цагаан хөтөлийн давааны 5 км авто зам, Хушаат сум сумын төвөөс хуучин төв хүртэлх авто замын 3 байршилд нийт 5 км замд гүн нүх үүсэж Хашаатын давааны 4 км, Ар тойлбын голын 12 метр модон гүүрний засвар, Орхон голын 235,2 у/м төмөр бетонон гүүрэнд засвар, Цагааннуур сум Оргихын адагт 5 км зам засварын ажлуудыг хийлгэх саналыг Зам тээврийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэн ургац хураалтын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд мал төллөлт 78,2 хувь, төл бойжилт 95 хувьтай байгаа бөгөөд мэдээг эцэслэж малын бүртгэл мэдээллийн цахим ситемд шивж оруулж баталгаажуулах ажил 20 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: Усны орлого 600.0 сая төгрөг төвлөрүүлсэн.

2023 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар гүйцэтгэх ажлын шууд гэрээгээр гүйцэтгэх “Байгалийн ховор ургамал тарималжуулах” ажлын гэрээг Баруунбүрэн суманд “Цээнэ” тарималжуулахаар иргэн Ж.Ширчмаа, Хүдэр суманд “Долоогоно” тарималжуулахаар иргэн Т.Тэгшжаргал, Ерөө сумын Бугант тосгонд “Жимсгэнэт өрөл” тарималжуулахаар “Бугант нөхөрлөл”, Хушаат суманд “Цээнэ, халиар” тарималжуулахаар “Хөвсгөл Их Тайга” ХХК-тай тус тус гүйцэтгүүлсэн.

2023 оны байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар “Ойжуулалт, ойн зурвас байгуулах, бургасжуулах” ажлыг “Ойн хүрэм” ХХК, “Модны эмч” ХХК-аар гүйцэтгүүлсэн.

Төрийн болон төсвийн 321 байгууллага, 501 аж ахуй нэгж, 2735 өрх, нийт 5948 иргэн, ерөнхий боловсролын дунд сургуулийн 428 сурагчдыг хамруулж, 593,9 тн хог, хаягдал цэвэрлэж, 12 нүхэн жорлонг буулгаж, ариун цэврийн байгууламжийг сайжруулж, нийт 1496 мал, амьтны сэг зэмийг төвлөрсөн хогийн цэгийн ойр нүх ухаж ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж устгасан.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэхээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 22 төсөл ирүүлж, 21 төсөлд “Нөхцөл болзолтой хэрэгжүүлэх боломжтой” гэж дүгнэлт гарган 1 төслийн холбогдох материал дутуу тул буцаасан байна.

“Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 2023 онд захиалагч “Оюу толгой ХХК”, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ийн санхүүжилтээр Ерөө сумын “Ялбагт” “Бугант нандин” ХХК, “Үзэгт дэлгэр” ХХК-ууд, “Харганат”, “Могойд” “Жинжий майнинг” ХХК, “Бугантын Өвөр залаат /35-ын ам/”, Гозон шард “Тотал идеал констракшн” ХХК-уудад нөхөн сэргээлтийн ажлыг хяналт шалгалтын явцад 30-аас 50 хувийн гүйцэтгэлтэйгээр нийт 124 га талбайд нөхөн сэргээлтийг хийсэн.

Дүйцүүлэн хамгааллын нөхөн сэргээлтийг Ерөө сумын Бугант тосгоны “Их өлөнт” гэх газарт “Хөтөл ЦШХК” заагдсан байршилд 6 га талбайд хийсэн.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр: Сумдын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр батлагдсан газар эзэмших эрхийн дуудлага худалдааг Алтанбулаг, Сайхан, Зүүнбүрэн сумдад зохион байгуулж, Орхон, Хүдэр сумдад зохион байгуулах дуудлага худалдааны зарыг газрын цахим бирж болон “Зууны мэдээ” сонинд байршуулан ажилласан.

2023 оны газрын төлбөрийн ногдуулалт үүссэн боловч нэхэмжлэл үүсгээгүй шинэ төлөвтэй байсан 15 сумын 4256 ногдуулалтаас 5 сумын 1846 шинэ төлөвтэй ногдуулалтад нэхэмжлэл үүсгэн татварын удирдлагын нэгдсэн системд илгээж ажилласан.

Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төслийн төсөөллийг хянуулахтай холбогдуулан газрын орлого болон, дуудлага худалдааны орлогын тооцоог гаргаж аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэн ажилласан.

Сүхбаатар сумын инженерийн шугам сүлжээтэй газарт нийт 114 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Орон нутгийн өмчийн газрын чиглэлээр: Засгийн газрын тохируулагч агентлаг-Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 417 дугаар тогтоолоор татан буулгахтай холбогдон Сэлэнгэ аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг Орон нутгийн өмчийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Мал эмнэлгийн газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар Боловсрол, шинжлэх ухааны газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Аймгийн Засаг даргын Тамгын газар, Стандарт хэмжилзүйн хэлтэс зэрэг 11 байгууллага руу шилжүүлэх тогтоолын төслийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.

288 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж гэрээ байгуулах эрх олгосон.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 10 байгууллагын нийт 498,4 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг актлуулж 8 байгууллагын нийт 382,2 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдаж, 3 байгууллагын нийт 382,3 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг шилжүүлэх тогтоол гаргуулан ажиллалаа.

1,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төсөл арга хэмжээний тендерийн баримт бичиг боловсруулж тендер зарласан.

Хяналт шалгалтын ажлын хүрээнд: Ерөө сумын “Болд төмөр Ерөө гол” ХХК, “Инфинтиспейс” ХХК, Хүдэр сумын “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн “Төмөртэйн” уурхай, “Эрдэс групп” ХХК-уудын холбогдох албан тушаалтан, мэргэжилтнүүдийг байлцуулан “01.1.4” кодтой “үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас”-аар шалгалт хийж, “Эрдэс групп” ХХК-ийн үйл ажиллагаа эхлээгүй зогссон, засвар үйлчилгээ хийсэн байдалтай, “БТЕГ” ХХК, “Төмөртэйн уурхай”, “Инфинити спейс” ХХК-ууд нь бага эрсдэлтэй үнэлэгдлээ.

Ерөө сумын Бугант тосгоны нутаг дэвсгэрт хууль бус олборлолтын байдалд хийсэн хяналт шалгалтын явцад мөн зарим эвдэрсэн газрын хэмжээг тогтоож, Ерөө сумын нутагт хийгдэж буй нөхөн сэргээлтийн ажлын явц байдалд газар дээр нь танилцаж, нийт 71,6 га талбай эвдрэлд өртсөнийг ерөнхий байдлаар тогтоогоод байна.

“Техникийн ашигласан тос, хаягдал аккумуляторыг тээвэрлэх, хадгалах, ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу уул уурхайн аж ахуйн нэгж, байгууллагуудад холбогдох хяналтын хуудсаар шалгалт хийж эрсдэлийг тогтоон, судалгаа танилцуулгыг хүргүүлсэн.

Орхон сумын 1 иргэнд холбогдох хориотой үед загас агнасан зөрчилд 300 мянган төгрөгийн торгууль, 390 мянган төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж барагдуулан 22 ширхэг загасыг улсын орлогод хураан авсан.

Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын ерөнхий байцаагчийн баталсан 02-00/12 дугаартай төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу Жавхлант, Ерөө, Шаамар, Сант, Орхон, Цагааннуур сумдад хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэн улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага өгч биелэлтийг тооцон ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтийг Жавхлант, Ерөө, Шаамар, Сант, Орхон сумдад шалгаж, 4 аж ахуйн нэгж, 2 иргэнд “Зөрчлийн тухай хууль”-ийн дагуу “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа” явуулж, торгууль оногдуулж, бусад аж ахуйн нэгж, иргэнд зөрчлийн хэрэг нээж, хэрэг нээсэн тогтоолын хуулбарыг хүргүүлсэн.

Сэлэнгэ аймгийн прокурорын газрын Ахлах прокурор, хууль цаазын итгэмжит, зөвлөх А.Баясгалан “Эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгох-4 “Эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг өөрчлүүлэх-5, нийт 9 дүгнэлтийг бичиж шүүхэд, шүүгчийн захирамжийн дагуу 9 эсэргүүцэл тайлбар бичиж, шүүгчийн туслахад хүргүүлсэн.

Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

2023 оны 7 дугаар сарын 18, 19, 20-ны өдрүүдэд Хоёр элс, Их овоо, Буур хээр, Сэлэмт хөшөө, Гүн нуур, Хяраан голын чиглэл болон төвийн хогийг цэвэрлэж нийт 20 тонн хогийг хогийн цэгт төвлөрүүллээ.

Сумын хэмжээнд 21456 хээлтэгч мал төллөхөөс 14769 толгой хээлтэгч төллөж, 68.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд: Адуу-356, Үхэр-1947, Хонь-7654, Ямаа-4812. Нийт 564 төл хорогдсон, бойжиж буй төл нь 14205. Зүй бусаар хорогдсон малын тоо Адуу-202, Үхэр-692, Хонь-597, Ямаа-583 нийт 2074 толгой байна.

Алтанбулаг сумын Бөхлөө гэх газарт 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдөр зохиог байгуулсан Цөх 3 дугаар багийн өдөрлөгт оролцон Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилт, малчдын хүлээх үүрэг, Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн хэрэгжилт, Мал ангилалтын талаарх ойлголт, ялган тэмдэглэл,

бүртгэлжүүлэлтийн ач холбогдлын талаарх мэдээллийг малчдад хүргэн ажилласан.

2023 оны 07 дугаар сарын 23-ны өдөр Цөх 3 дугаар багийн Бөхлөө чиглэлд "Иргэн таныг сонсьё" нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж ард иргэдэд мэдээлэл хүргэн ажиллалаа.

Баруунбүрэн сум:

Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн төслийн хүрээнд 2 хоршоо, 1 жижиг дунд үйлдвэрлэгч нийт 3 төсөл хэрэгжүүлэгчид 90 сая төгрөгийн зээлийг санхүүжүүлэн ажиллаж байна.

Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ээлжит хурал 07 дугаар сарын 18-ны өдөр хуралдаж сумаар дайран өнгөрөгч Эрдэнэт-Дарханы авто зам дагуу зам тээврийн осол, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор гэрэл ойлгогчтой зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх самбар байршуулах талаар хуралдаж шийдвэрлэн ажиллаж самбаруудыг авто зам дагуу байршууллаа. Мөн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Уусан бол бүү жолоод", "Хамгаалах бүс", "Хамгаалах малгай" зэрэг аяныг сумын нутаг дэвсгэрт зохион байгуулж иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

Тус сумын 1-р цэцэрлэг нь 06 дугаар сарын 12-оос 07 дугаар сарын 05-ны хугацаанд хувилбарт сургалтыг Бургалтай 2-р багийн нутаг Жаргалантад ажиллуулж малчдын 52 хүүхдийг 100 хамруулан сургалт үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа.

Төрийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан операторын горимоор үзүүлэх үйлчилгээг "e-mongolia.mn" хаягаас нийт 109 иргэн 109 лавлагаа мэдээлэл, "e-business.mn" хаягаас 6 аж ахуйн нэгж тоон гарын үсгээр 7 лавлагаа гарсан байна. Нийт 32 иргэнд "И-Монгол" аппликэйшеныг хэрхэн хэрэглэх, ашиглах талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн.

Баянгол сум:

Үндэсний их баяр наадам болж буйтай холбогдуулан Үндэсний их баяр наадмын тухай хууль /шинэчилсэн найруулга/, Хурдан морины унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS 6264:2018 стандартын талаарх мэдээллийг даатгалын компани болон уяач нарт хүргэж, сурталчлан гарын авлага тарааж, 2023 оны 07 дугаар сарын 19,20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан сумын баяр наадам, 2023 оны 07 дугаар сарын 23,24-нд зохион байгуулагдсан Сэлэнгэ аймгийн хурдан морьдын бүсийн уралдаанд хүүхэд хамгааллын баг ажиллуулан уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажиллалаа.

7 дугаар сарын эхээр үргэлжлэн орсон борооны улмаас Хараа гол үерийн аюултай түвшинг давж үерлэсэн. Сумын онцгой комисс хуралдаж шуурхай штабыг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан 24 цагаар үүрэг гүйцэтгэн ажилласан. Сумын хэмжээнд 27 дуудлага мэдээлэл ирж хөдөө амьдардаг 42 айл өрх, төв суурин хэсгийн 20 өрх нийт 62 өрхийн 433 хүн байгаагаас 167 хүүхэд, 266 том хүн голын усанд боогдож гарах боломжгүй байсныг хүн хүч техник хэрэгсэл ашиглан гаргаж аюулгүй газар нүүлгэн шилжүүлсэн. Мөн ард иргэдэд үер уснаас сэрэмжлүүлэх мэдээг тогтмол өгч, гарын авлагыг тарааж урьдчилан сэргийлэх ажиллагаанд 91 хүн, 25 техник хэрэгсэл хамрагдсан.

Сумын албан ёсны цахим хуудсыг шинэчлэх ажил хийгдэж байна. 7 дугаар сард сумын татварын орлогын төлөвлөгөө 297,810.8 мянган төгрөг батлагдсанаас 47,688.5 мянган төгрөг төсөвт төвлөрсөн.

2023 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт болон аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх нийт 1,347.7 сая төгрөгийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, гэр хорооллын явган хүний замыг хатуу хучилттай болгох, худаг гаргах, хогны машины мотор хроп авах, цахим худаг засвар, мал ариутгалын дүк машин авах, ковш худалдан авах ажлын гэрээ байгуулан ажиллаж байна. Нийт 222.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Тусгай зориулалтын шилжүүлгийн болон орон нутгийн төсвөөр санхүүждэг төсвийн байгууллагуудад 100% санхүүжилтийг олгож шилэн дансны мэдээллийг хугацаанд нь тогтмол оруулж хэвшсэн ба 28 мэдээ, тайланг шивж оруулсан.

Хараа багийн Зүрх, Хавчуу, Баян багийн Тариат, Наран, Хар морьт, Хустай, Гонир багийн Өлөнт, Сэвсүүл чиглэлд хууль бус мод бэлтгэх болон ангийн эргүүл шалгалтыг 8 удаа хийсэн.

Нөхөн сэргээлт 2024 арга хэмжээний хүрээнд замын 4-н аж ахуй нэгжийг шалгаж нөхөн сэргээлт хийсэн 10 карьерыг газар дээр нь очиж шалгаж зөвлөгөө өгсөн. Үер уснаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Хараа гол дагуу зусаж байгаа 20 айл өрхөөр орж нүүх албан мэдэгдэл өгсөн.

Сумын хүн амын тоонд тулгуурлан өргөн хэрэглээний гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөцийг 7 хоног бүр тодорхойлж бүтээгдэхүүний хүрэлцээг тогтвортой байлгах, нөөц бүрдүүлэлт, дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт тавих, өргөн хэрэглээний гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөцийн судалгааг 7 хоногийн даваа гариг бүр программд шивж байна.

Хоршоо хөгжүүлэх сангаас 2022-2023 онуудад төсөлд хамрагдсан хоршоо, аж ахуй нэгж иргэдийн төсөл хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөл Хараагийн баян үрс, Хүүгийн хишиг ХХК, Түмэн дэвших хоршоо, Түмэн хараа ХХК, Баян багийн иргэн Л.Дүүриймаа, Хараа багийн иргэн П.Туяа, Хараа багийн иргэн Л.Занданчимэг, Баян багийн иргэн Д.Нямсүрэн, Б.Энхцацрал, Ч.Ичинхорлоо нарын төслийн хэрэгжилтэд хяналт тавьж газар дээр нь ажилласан.

Хоршоог хөгжүүлэх сангийн 2023 оны 06 дугаар сарын эргэн төлөлтийн хуваарийн дагуу 11 зээлдэгчийн 6,3 сая төгрөгийг сангийн дансанд төвлөрүүлсэн.

Ерөө сум:

Их Буурагчин хайрхны тахилгын ёслолыг 07 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж тэмдэглэн өнгөрүүллээ. Уг арга хэмжээнд Их хайрхнаа тахиж, шүдлэн насны морь уралдуулан, 6-15 насны хүүхдүүдийн дунд Үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулж нийтдээ 130 хүүхэд багачууд хамрагдлаа.

Малын удмын сангийн мэргэжилтэнтэй хамтран Буурагчин 2-р багийн 2 малчин өрхийн 107 үнээнд улаан ангус, лимузин үүлдрийн гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлгийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Газар тариалангийн үйл ажиллагаа эрхлэгч 14 аж ахуйн нэгж, 5 иргэний нийт 8376,2 га талбайд улаан буудайн соёололтын ажлыг зохион байгууллаа. Улаан буудайн соёололт 4564.58 га буюу 54.49 хувь онц, 3353.77 буюу 40.0 хувь сайн, 457.78 га буюу 5.46 хувь дунд зэргийн соёололттой гарсан байна.

Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 85400 богийг хамруулж, тарилгын цувааны материал, мал эмнэлгийн цахим системтэй тулгаж 58567 бог, адуу 2976, үхэр 18296 нохой 60, гахай 300 нийт 80199 мал амьтныг туулгаж гүйцэтгэл 94 хувь байна. Боловсруулалт: 58567-бог, үхэр 18296, нохой 62, гахай 300 нийт 77225 мал амьтныг хамруулсан гүйцэтгэл 99 хувьтай явагдаж байна.

"Залуу малчдын уулзалт" арга хэмжээний үеэр гарсан санаачилгын дагуу 1-р багийн Хужирт, Шаазгайт, Хангайн даваа хэсгийн малчин залуус өөрсдийн хөрөнгө, хүчээ дайчлан ЕРӨӨ САМБАР -аас ШААЗГАЙТ хүртэлх 20 км зам дагуух

хог хаягдлыг түүж цэвэрлэн 6 портер 4 тн орчим хогийг сумын төвлөрсөн хогийн цэгт буулгалаа.

Гэр бүл хүүхдийн хүчирхийлэлтэй тэмцэх хөршийн холбооны гэрээг Буурагчин багийн Энхтал хэсгийн 55 өрхтэй байгуулан ажилласан.

Хүнсний аюулгүй байдлыг хангах, нийтийг хамарсан хоол хүнсээр дамжих, өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, бараа бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зорилгоор суманд үйл ажиллагаа явуулдаг худалдаа үйлчилгээний 12 аж ахуй нэгж байгууллагад баяр наадамтай холбогдуулж төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгууллаа.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2023 оны 85 тоот тогтоолыг үндэслэн баталсан хуваарийн дагуу ойгоос мод бэлтгэх эрхийн бичгийг ойн цэвэрлэгээний ажлаар 11 иргэн, 2 аж ахуйн нэгжид мод модон материалын гарал үүслийн гэрчилгээг олгосон байна.

Мөн сумын Засаг даргын 2023 оны 04 тоот удирдамжийн хүрээнд 2-р багийн нутаг Ялбаг, Бэрлэгийн цагаан тохой чиглэлд хууль бус ашигт малтмал, мод бэлтгэл, ан агнах, загас барих чиглэлээр хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн ойн санг гэрээгээр эзэмшигч 1, уул уурхайн 3 нийт 4 аж ахуйн нэгж, 30 иргэнд байгаль орчны багц хууль болон холбогдох гарын авлага бэлтгэн тараалаа.

Жавхлант сум:

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Сургуулийн дотуур байрны гадна пассат, цонхны засварын ажил”-173,0 сая төгрөгийн төсөвтэй 100 хувь, аймгийн замын сангийн хөрөнгө “Хатуу хучилттай авто зам”-289,3 сая төгрөгийн төсөвтэй 50 хувь, Жавхлант сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар сумын Засаг даргын Тамгын газрын их засварын ажил-20,0 сая төгрөгийн төсөвтэй 100 хувь, Соёлын төвийн урлагийн хувцас нэмэгдүүлэх ажил -10,0 сая төгрөгийн төсөвтэй 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Мөн Малын тоо толгойн албан татварын хөрөнгө оруулалтаар Гэмт халдлага гамшгаас хамгаалах /Цагдаагийн албанд авто машин худалдан авах/-25,0 сая төгрөгийн төсөвтэй 100 хувь, Малын эрүүл мэндийг хамгаалах ажлын хүрээнд /Ариутгал халдваргүйтгэл хийх автомат ДҮК машин худалдан авах/-73,0 сая төгрөгийн төсөвтэй 100 хувь, Олон улсын төсөл хөтөлбөр, бусад хөрөнгө оруулалтаар Стрийм төсөл Тэрбум мод аяны хүрээнд стрийм төсөл мод жимсний үржүүлгийн ажил. /1000 ш улиас 1000ш бургас таригдсан. Үрээр- агч, буйлс, гүйлс, шар хуайс/ тарьж 100 хувийн гүйцэтгэлтэй тус тус байна.

Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас Жавхлант суманд цэцэрлэгт хүрээлэн байгуулах-20,0 сая төгрөгийн төсөвтэй 30 хувь, Хүлэмж 8*60 м 2ш өөрийн хөрөнгө 10,0 сая төгрөг, сум хөгжүүлэх сан 20,0 сая төгрөгийн хөрөнгө нийт 30,0 сая төгрөгийн хөрөнгөөр 100 хувь, Дотуур байранд хүүхэд хөгжлийн танхимыг Дэлхийн зөн олон улсын байгууллагын 8,4 сая төгрөгийн төсөвтэй 100 хувь, Ажилчдын байр дотор засал-10,0 сая төгрөгийн төсөвтэй 100 хувь, Усан сан өөрийн хөрөнгөөр 10,0 сая төгрөгийн төсөвтэй 100 хувийн гүйцэтгэлтэй тус тус байна.

Соёлын төвөөс бүжгийн зуны сургалтыг хичээллэж нийт 39 хүүхэд хамрагдаж баяр наадмын нээлтийн тоглолтод оролцлоо.

Удаан хугацааны хур борооны улмаас усны түвшин эрс нэмэгдэж голын ус савнаасаа халин үерийн усны аюул нүүрлэж байна. Үерийн усанд боогдсон голын ай саваар суурьшсан айл өрхийг нүүлгэн шилжүүлж үерийн усны аюулаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг ард иргэд болон голын ай саваар суурьшиж буй айл өрхөд мэдэгдлээ.

2023 онд Жавхлант суманд 5 аж ахуйн нэгж, 65 иргэн төмс 52га, хүнсний ногоо 308.6га, нийт 360.6га газар төмс, хүнсний ногооны тариалалт хийгдсэн дүн мэдээг цахим бүртгэлд оруулсан.

Зүүнбүрэн сум:

Аймгийн Засаг даргын 2023 оны “Сумдын баяр наадмын товыг тогтоох тухай” захирамжийн дагуу Их Монгол Улс байгуулагдсаны 817 жил, Ардын хувьсгалын 102 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 92, Зүүнбүрэн сум байгуулагдсаны 99 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлээ.

Аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний газар болон сумын ус цаг уурын ажилтан, усны харуулаас тухай бүр шаардлагатай мэдээ, мэдээллийг авч, цаг алдалгүй иргэд, тариаланч, малчдад хүргэн ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссын 2023 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг ханган үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг ханган сэрэмжлүүлэг мэдээг гол, мөрөн даган зуншиж байгаа Бэлчир 2дугаар багийн нутаг Охиндий, Буурлын үүр, Гангын тохой, Таван зуу, Сүмийн булан, Цагаан ус, Мангирт 3 дугаар багийн нутаг Бага-Өлгий, Зүр хангай, Манхан чиглэлийн гол, мөрний ойролцоо үерт өртөж болзошгүй 149 өрхөд сануулга зөвлөмж хүргэн нүүлгэсэн. Мангирт 3 дугаар багийн Өндөр хүрийн дор Бага-Өлгий гэх газар 9 өрхийн 27 хүүхэд, 13 том хүн нийт 40 иргэн усанд боогдсон байдалтай байсныг аймгийн Онцгой байдлын газрын 5 албан хаагч, сумын иргэд нийлсэн 15 хүн ажиллаж 0-18 насны 27 иргэн, 18-аас дээш насны 13 иргэнийг аюулгүй гаргаж авсан.

Мөн үерт боогдсон байсан 1020 толгой бог малын 45 толгой усанд живсэн байдалтай байсанд аврах ажиллагааг нутгийн залуус, сумын Онцгой комиссын албан хаагчид болон нийт 38 иргэний бүрэлдэхүүнтэй 5 завьтай ажиллаж 975 толгой бог малыг уснаас гаргасан.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 10 дугаар хуралдааны тэмдэглэл, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2023 оны “Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/125 дугаар тушаал, сумын Засаг даргын 2023 оны А/108 тоот захирамжийн хэрэгжилтийг хангаж, бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх био тарилгыг “Оюутсүрэг”, “Энхбүрэн сүрэг” МЭҮН-үүд нийт 80704 толгой бог малыг дархлаажуулалтад хамруулж ажиллалаа.

Газар тариалангийн цахим бүртгэлд аж ахуйн нэгж, иргэдийг бүртгэх ажлыг эрчимжүүлж 17 аж ахуйн нэгж, 270 тариаланч, 17419.6 га талбайг бүртгэлжүүлээд байна.

Сумын Жаргалант, Майхан толгой орчмын 165 га талбайн Хайлаасанд хортон шавжийн устгалын ажлыг зохион байгуулж малчин, мал бүхий иргэдэд малаа бэлчээхгүй байх талаар анхааруулга өгч ажиллалаа.

Мандал сум:

Мэдээллийн ил тод байдлыг хангах, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх зорилгоор зохион байгуулагдаж байгаа ажил үйлчилгээ, түүнтэй холбоотой мэдээлэл, цаг үеийн мэдээллийг фото, видео хэлбэрээр бэлтгэн ажиллалаа. МАНДАЛ СУМЫН ЗДТГ-ын албан ёсны цахим хуудсаараа дамжуулан нийт 162 мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэжээ. Давхардсан тоогоор мэдээ мэдээлэл, видео бичлэгийг 61,580 хүн үзсэн хандалтын үзүүлэлттэй байна. Видео-17 хэлбэрээр сумын Засаг даргын Тамгын газрын албан ёсны цахим хуудсанд цаг үеийн мэдээ 36, үйл явдлын мэдээ 82, сэрэмжлүүлэг мэдээ-23, Постор-17 мэдээ, мэдээллийг бэлтгэн байршууллаа.

Сумын хэмжээнд 2023 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн үргэлжилсэн хур бороо орсны улмаас Хараа голын том, жижиг гүүрэнд нуралт, 5 багийн нутаг

дэвсгэрт үеийн далан сэтэрч үерийн гамшгийн нөхцөл байдал үүссэн. Сумын Онцгой комисс 7 удаа хуралдаж тулгамдаж асуудлыг бүрд шийдвэрлэн ажилласан. Сумын хэмжээнд үерийн улмаас 1 аж ахуйн нэгж байгууллага, 133 гэр, 3 нүхэн гарц усанд автсан, 5 далан, гүүр задарсан байсныг шуудуу татах, усанд боогдсон иргэдийг нүүлгэн шилжүүлж, 1 удаагийн усны осол, 2 цахилгааны шон унасан дуудлагаар үүрэг гүйцэтгэж, эрэн хайх ажиллагааг зохион байгуулан ажилласан.

Төмөр замын 1-р баг, Баянхангайн 6-р баг, Баянсуудлын 3-р баг, Ширхэнцэг 2 дугаар баг, Хэрх 4-р баг нийт 5 багийн 6 үерийн далан сэтэрсэн байсныг төр, төсвийн болон хувийн хэвшлийн 20 аж ахуй нэгж байгууллагын 170 ажилтан, албан хаагч, иргэд 61 техник хэрэгслээр сэргээн засварласан. Мөн Баянхангайн 6 дугаар багт байрлах үерийн далангийн гүүрийг шинэчлэн завсарлах ажлыг “Спирт Бал Бурам” ХХК хийж гүйцэтгэв.

Үерийн далангийн ус 2 талаараа хальж давж урсаж байна гэсэн дуудлагыг ирсний дагуу үерийн далангийн намхан хальж урсаж байгаа хэсгийн өндөрлөж бетон гүүрний 2 талыг урсган, усны урсгалыг чөлөөлснөөр Ноёд, Баруун өлөнт, Дунд өлөнтийн нүүрний, стадионы баруун талын хэсгийн 189 айл өрхийг ус хальж орохоос урьдчилан сэргийлэн ажиллаж нийт 8 техникт 20 гаруй иргэд ажиллалаа.

Мандал сумын хэмжээнд Төмөр замчдын 1 дүгээр багийн 16 өрх, Ширхэнцэг 2 дугаар багийн 40 өрх, Баянсуудал 3 дугаар багийн 100 өрх, Хэрх 4 дүгээр багийн 102 өрх, Түнхэл 5 дугаар багийн 93 өрх, Баянхангай 6 дугаар багийн 45 өрх, Минжийн хангай 7 дугаар багийн 12 өрх, Тарни 8 дугаар багийн 58 өрх, Баян-Арцат 9 дүгээр багийн 16 өрх, нийт 482 өрх үерт автаж болзошгүй өрхийн судалгааг гаргаж аймгийн онцгой комисст хүргүүлж сумын 9 багийн Засаг дарга дээр нь очиж аюулгүй газар нүүх зөвлөгөө, мэдэгдлийг хүргүүлж ажилласан.

Мандал сумын хэмжээнд 9 автомашиныг усанд суусан байсныг аюулгүй газарт гарган, 133 айл өрхийн 740 иргэнийг нүүлгэн шилжүүлж, үер, усны аюулаас авран хамгаалж, заавар, зөвлөмж сэрэмжлүүлэг өгч ажилласан.

7 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн Том гүүрний хамгаалалтад Сум дундын Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтсийн албан хаагчид 24 цагаар 36 албан хаагч хамгаалалтын үүрэг гүйцэтгэн гүүрэн дээгүүр автомашин болон явган хүний хөдөлгөөнд хязгаарлалт хийн ажиллаж байна.

Онцгой байдлын хэлтсээс өдөр бүр 7 дугаар сарын 08-ны өдрөөс 1 техник хэрэгсэл, 4 алба хаагч, 1 завьтайгаар нэн шаардлагатай 1046 хүнийг завиар зөөвөрлөн ажилласан. Мөн эмнэлгийн 17 хайрцаг эм, эмийн бүтээгдэхүүн голоор тээвэрлэсэн. Аймгийн Онцгой байдлын газраас 10 ширхэг аврах хантааз ирсэн. Аврах ажиллагааны 5 ширхгийг хөвөгчийг захиалсан төсвийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөнөөс шийдвэрлэсэн. Хараа голын том гүүр эвдэрч нуралт үүссэн холбоотойгоор УБ хотоос Мандал сум руу салдаг авто замын хажууд Баруунхараагаар дамжин нэвтрэхийг анхааруулсан самбарыг байршууллаа. Зүүнхараагаас Баруунхараагаар Хэрх тосгон руу дамжих боломжийг олгож орох гарах авто зам, жижиг гүүрийг 3 өдрийн дотор янзалж иргэдийн зорчих хөдөлгөөнийг нээлттэй болгосон.

Үер усны онцгой үед ард иргэдийг нүүлгэн шилжүүлэх, эд хогшлыг авран хамгаалах Зил131 машины судалгаа гарган 12 ойн мэргэжлийн байгууллагын 19 Зил131 машиныг дайчлан ажиллуулж өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотойгоор Мандал суманд хүнд даацын ачааны машинуудыг дайчлан үйрэн улмаас эвдэрсэн 4 гүүрийг сэргээн засварлах, сумын төвийн үерийн даланг сэргээн эргийг өндөрлөх ажилд 4 иргэний экскаватор тракторыг дайчлах ажлыг удирдан зохион байгуулж ажилласан. “Түргүүр” барих ажил хийгдэж байна.

Төмөр Замчдын 1 дүгээр баг Дарьтын эхэнд төвөөс алслагдсан 120 малчин иргэдэд төрийн үйлчилгээг цогцоор хүргэн нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгууллаа.

Сумын амьжиргааг дэмжих зөвлөл 2 удаа хуралдаж нийт 78 иргэний өргөдлийг шийдвэрлэлээ. Үүнд: байнгын асаргааны тэтгэмжид ахмад настан шинээр хамрагдах-5, сунгалт-11, асрагч солих-1, хөгжлийн бэрхшээлтэй иргэн шинээр-3, сунгалт-10, асрагч солих-1, байнгын асаргаа шаардлагатай хүүхэд шинээр-1, сунгалт-8 тус тус шийдвэрлэн уламжлав. Тайлант сард хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд нийт 93 өрхийн 318 том хүн, 369 хүүхдэд хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлдэг 5 дэлгүүрээр 8120,0 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн олгож тайланг хугацаанд нь хүргүүлээ. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн журам өөрчлөгдөж 100 хувь олгох болсонтой холбогдуулан сумын нийт 9490 хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг цаг хугацаанд нь олгож ажиллалаа.

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын санаачилгаар Бүгд Найрамдах Солонгос улсын Жинжү хотын Сувилахуйн сургуулийн баг хамт олон Мандал суманд 7 сарын 18-19-ний өдрүүдэд ажиллалаа. Тус сайн дурын баг хамт олон 4 дүгээр сургуулийн спорт зааланд байрлан 2 өдрийн турш үс засалт, дотрын эмчийн үзлэг, зөвлөгөө, тохирсон эм болон витамин олгох зэрэг эрүүл мэндийн үйлчилгээ болон хүүхдүүдэд цаасан урлал, нүдний шил хийх, дэвүүр хийх, зураг зурахыг заах зэрэг боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явууллаа. Мөн сумын Нэгдсэн эмнэлгийн байранд 2 өдрийн турш шүдний үзлэг, эмчилгээ, хиймэл шүд хийх зэрэг эмнэлгийн тусламж үйлчилгээг давхардсан тоогоор 600 гаруй хүнд үнэ төлбөргүй үзүүллээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд харьяаллын дагуу шилжиж ирсэн 3 зөрчилд шалган шийдвэрлэх ажиллагаа явагдаж 1 зөрчлийн хэрэг хэрэгсэхгүй болж, 2 зөрчлийн хэрэгт 600,000 төгрөгийн торгуулийн шийтгэл оногдуулсан. Ой нээсэнтэй холбоотойгоор байгаль хамгаалагч нар ойн мэргэжлийн байгууллагын доод агуулахад 7 хоногт 2-3 удаа тогтмол хяналт тавьж ажилласан. 28 эрхийн бичгээр 136 тн элс, 1860 тн уулын дайрганы зөвшөөрөл олгогдож төрийн санд 1,928,000 төгрөгийг төрийн санд төвлөрүүлсэн байна. 5 эрхийн бичгээр 11 ширхэг загас барих эрх олгож 110,000 төгрөгийг төрийн санд төвлөрүүлсэн байна. Планетгоулд Монголиа төслөөс зохион байгуулсан “Алтны бичил уурхайн албажуулалд” сургалтад 1 улсын байцаагч, 2 байгаль хамгаалагч хамрагдлаа. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу 2024 оны төлөвлөгөөг Байгаль орчны мэдээллийн санд (www.eic.mn) сайтад шивсэн.

ХХААХҮЯамны судалгаа хөгжлийн төв, Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран сумын газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 150 иргэн, аж ахуй нэгжийн төлөөлөл, иргэдийг хамруулан Газар тариалангийн нэгдсэн систем (plant.mofa.gov.mn)-ийн ашиглалтыг сайжруулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх сургалтыг Сэлэнгэ аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулсан. Үерийн улмаас үүссэн газар тариалангийн хохир Хараа голын ойролцоо тариалангийн талбайтай 4 аж ахуйн нэгж байгууллага 22, айл өрхийн хүнсний ногоо 116.82 га, төмс 35.01, улаанбуудай 210 га талбай га, эрдэнэ шиш 40 га, ногоон тэжээл 35 га нийт 436.83 га талбай үерт авцсан судалгааг гаргасан. Сэлэнгэ аймгийн ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч Манай суманд ажиллан 27 өрхийн тариаланчид гарал үүсэл, ургамал төрөл бүрийг итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээгээ өгөх шаардлагатай талаар заавар зөвлөгөө өгч хяналт тавьж ажиллаа. .

“Цант Орхон” ОНӨААТҮГазар Ширхэнцэгийн 2 дугаар багт үерийн улмаас үүссэн хуримтлагдсан усыг татан зайлуулах, бохирын шугам хоолойн худгийн эвдэрсэн хэсгийг сэргээн засварлаж тэмдэг тэмдэглэгээг байршуулах ажлыг хийж

гүйцэтгэсэн. Айл өрх аж ахуй нэгжийг дэд бүтцийн бохирын шугамд холбох зорилго бүхий шугам суурилуулах ажлын үр дүнд одоогоор шугам холбогдсон хэсэгт 35 аж ахуй нэгж 11 айл өрх бохирын төвлөрсөн шугамд холбогдоод байна. Цаашид тус бохирын шугам хоолойн ашиглагчаар "Цант Орхон" ОНӨААТҮГазар хариуцан ажиллах бөгөөд гүйцэтгэгч компанийн ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллана.

Орхонтуул сум:

Орхонтуул ЗДТГ, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум фэйсбүүк хуудас, Рашаант тосгон зарын групп, Рашаант тосгон захирагчийн алба фэйсбүүк хуудас болон Orkhontuul.se.gov.mn веб сайтад 12 төрлийн урьдчилан сэргийлэх болон цаг үеийн мэдээлэл, 5 шторкийг бэлтгэн байршуулсан.

7 дугаар сард үргэлжилсэн усархаг бороо ихээр орж байгаа тул томоохон гол, мөрөн, нуур, цөөрмийн усны түвшин нэмэгдэж байгаа тул урьдчилан сэргийлж голын ай, сав, гуу жалга, үерийн усны буулт бүхий газраар нутаглахгүй байх, гарамгүй газраар гол, ус гатлахгүй мөн амралт зугаалгын улирал эхэлсэнтэй холбогдуулан бага насны хүүхдэд тавих хараа хяналтаа сайжруулах, гол нуурын усанд орохгүй байхыг анхааруулсан 357 мэдээ мэдээллүүдийг цахим хуудсанд байршуулж 357 лайк, 99 шейр, 1352 хандалт авсан байна .

Тайлант хугацаанд 108 дуудлагын утсанд 2 дуудлага ирж хамтарсан багаар ажилласан. Үндэсний их баяр наадмаар хурдан морь унасан 65 хүүхэд бүртгэж программд шивж оруулсан. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас ирүүлсэн Эрсдэлт бүлгийн программд бүртгэлтэй 5 өрхөд багцийг тараан өгсөн.

7 дугаар сарын байдлаар Хоршоо хөгжүүлэх сангийн 100131055401 тоот дансанд 4,025,812 төгрөгийн орлого ороод байна.

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зарласан Баянцогт 2-р багийн 1 орцтой орон сууцны барилгын дээвэр засвар, орцны хаалга шинээр солих ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Гонирын зам" ХХК-ийн ажлын гүйцэтгэл 80 хувьтай явагдаж байна.

Баянцогтын 2-р багт Бэлчээрийн худаг гаргах, Орхонтуул сумын Зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлэг, ариутгалын багаж хэрэгсэл худалдан авах ажлуудын нээлт хийхэд оролцсон аж ахуйн нэгж байгаагүй тул дахин тендер зарлаад байна.

Орхон сум:

Тулгар төрийн 2232, Их Монгол Улсын 817, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112, Ардын хувьсгалын 102 жил, Орхон САА байгуулагдсаны 80 жил, Орхон сум үүсгэн байгуулагдсаны 64 жилийн ойн баяр наадам амжилттай зохион байгуулагдлаа. Баяр наадмын үеэр дараах иргэдийг шагнаж урамшууллаа.

Мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд иргэд, олон нийтэд цаг үеийн мэдээ мэдээллийг фото мэдээлэл, шторк, сурталчилгаа хэлбэрээр "Сэлэнгэ Орхон сум ЗДТГ", "Сэлэнгэ аймгийн Орхон сум" "Нарт Орхоны хүүхдүүд" "Selenge Orhon Emt" зэрэг албан ёсны фэйсбүүк хаягуудад байршуулан 18 удаагийн мэдээ мэдээллийг хүргэж давхардсан тоогоор 852 хүний хандалтыг авсан байна. Мөн иргэд, малчид, тээвэрчдэд зориулан Орхон цаг уурын станцаас цаг агаарын урьдчилсан мэдээг 5 хоног тутам тогтмол хүргэж байна.

Бэлэндалай багийн Гүнжийн булангийн хадлангийн талбайг "Малын тоо толгойн албан татварын орлого"-оор буюу 20,000,000 төгрөгийн өртөгтэйгээр "Малчдын бүлэг" болон "Бэлчээр ашиглалтын холбоо"-той хамтран хашаажууллаа.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 35.286.604 төгрөгийн төсөвт өртөгтэйгээр Бэлэндалай багийн "Хүүхдийн тоглоомын талбайн тохижилт сайжруулах" ажлыг "Дөлгөөн хангай түшиг" ХХК гэрээний хугацаандаа 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хүлээлгэн өглөө.

Сант сум:

Аймгийн Онцгой комиссын 2023 оны 02 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангах, болзошгүй үер, усны аюул ослоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сумын Засаг даргын “Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” А/109 дүгээр захирамжаар баяр наадмын өдрүүдэд хяналт тавьж ажиллах хариуцлагатай эргүүл жижүүрийг томилон ажиллууллаа.

Сумын хэмжээнд гол дагуу зусаж байгаа, үерт өртөж болзошгүй 8 өрхөд мэдэгдэх хуудас хүргүүлж шаардлагатай тохиолдолд нүүлгэх арга хэмжээ авах, Орхон гол дагуу төмс хүнсний ногоо тариалагч иргэд аж ахуйн нэгжийн судалгааг гаргаж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан. Орхон голын эрэг дагуу нийт 18 иргэн, 1 аж ахуйн нэгж 195 орчим га талбайд төмс, хүнсний ногооны тариалалт хийснээс нэг аж ахуйн нэгжийн тариалсан 14 га төмс, хүнсний ногооны талбай усанд боогдож, 1 иргэний 1 га талбай үерт автсан байна.

Урин дулаан цагт гол, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор Сант сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Засаг даргын Тамгын газар, Сайхан сумын гал түймэр унтраах, аврах 061 дүгээр анги, Сайхан сумын сум дундын Цагдаагийн хэлтэс хамтран Орхон голын гүүрний доор 150 метр газарт хамгаалах тор татаж хашаажууллаа.

Малын удмын сангийн үндэсний төвтэй хамтран бод малын зохиомол хээлтүүлгийн ажлыг 7 дугаар сарын 3-10-ны өдрүүдэд зохион байгууллаа. Энэ ажлын хүрээнд 14 өрхийн 100 үхэрт ороо идэвхжүүлэгч тарьж Геррефорд цэвэр үүлдрийн GERD хочтой бухын гүн хөлдөөсөн үрээр үрлэгээ хийлээ.

Сумын ойн сангийн 1800 га талбайд ойн хөнөөлт шавж устгалын ажлыг авиа химийн аргаар зохион байгуулж мэргэжлийн байгууллага “Мөнх ногоон жодоо” ХХК гүйцэтгэлээ.

Тулгар төрийн 2232, Их Монгол улс байгуулагдсаны 816, Ардын хувьсгалын 102 жил, Сант сум үүсгэн байгуулагдсаны 95 жилийн ой, үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны үеэр Хүүхэд хамгааллын тухай хууль, Сайхан сумын сум дундын цагдаагийн хэлтсийн 2023 оны 07 сарын 05-ны өдрийн 81 дугаар мэдэгдлийг хэрэгжүүлэн ажилласан. Хурдан морины уралдаанч хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, хурдан морины эзэн, уяач нарын хооронд давхардсан тоогоор 51 аюулгүй байдлын гэрээг хийлгэж, уяач, унаач хүүхэд бүрийг батлагдсан маягтын дагуу бүртгэж, стандартын хувцас хэрэгслийн бүрэн бүтэн байдал, эцэг эхийн зөвшөөрөл авсан эсэх, хүүхдийн эрсдэлийн даатгалд хамрагдсан байдалд хяналт тавьж ажиллалаа. Уралдааны үеэр унаач хүүхэд унаж бэртэх болон ямар нэг эрсдэл гараагүй болно.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар "Төрийн албан хаагчдын 12 айлын байрны дээвэр засвар, хогийн бункер барих" ажлыг 87.000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр "Нарт оргил өргөө" ХХК зураг төсвийн дагуу 100 хувь гүйцэтгэсэн.

Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласантай холбогдуулан авлигын эсрэг үйл хэрэгт хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх, авлигыг мэдээлж, ШҮГЭЛ үлээхийг уриалсан “НЭГДЬЕ” нөлөөллийн аяны хүрээнд сумын цахим хаягт 11 удаагийн шторк, инфографик, зөвлөмжийг байршуулснаас 62 хандалт авч, 13 удаа хуваалцсан байна.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 733 хүүхдэд 73300,0 мян. төгрөг, тэтгэвэр тэтгэмж 39 иргэнд 13000,0 мян. төгрөг, асаргааны тэтгэмж 44 иргэнд 12465,3 мян төгрөг, эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж 97 иргэнд 4533,2 мян. төгрөг, 1 ахмад настанд оршуулгын зардалд 2000,0 мянган төгрөг, насны хишиг мөнгөн тэтгэмжид 1 ахмад шинээр бүртгэгдэн 50,0 төгрөг нийт 182 иргэнд 32048,5 мянган төгрөг олгосон.

Сайхан сум:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 01/1006 тоот “Үүрэг, чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн хүрээнд авлигатай тэмцэх газраас “Шүгэл үлээх ажиллагаа”-ны хүрээнд зохион байгуулагдаж буй “нэгдье”, “үгүй гэж хэлээд өөрчилье” авлигын эсрэг нөлөөллийн аянд Сайхан сум нэгдэж төлөвлөгөө боловсруулан, батлуулж нөлөөллийн аяныг сумын хэмжээнд зохион байгуулан ажилласан.

Тус төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагчид авлигатай тэмцэх газраас “Шүгэл үлээх ажиллагаа”-ны хүрээнд зохион байгуулагдаж буй “Нэгдье”, “Үгүй гэж хэлээд өөрчилье” авлигын эсрэг нөлөөллийн аянд нэгдэн ажиллаж байна.

2.Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан видео, шторк, контентыг сумын цахим хаяг болон төр төсвийн байгууллагын цахим хаягаар олон нийтэд хүргэн ажиллалаа.

3.Төр төсвийн байгууллагууд болон иргэдэд нийт 150 ширхэг гарын авлага, боршур тарааж Авлигын эсрэг хуулийг сурталчлан ажиллалаа.

4.Авлигын эсрэг олон нийтийн ёс зүй ухамсар сэтгэлгээг өөрчлөх сургалтыг сумын Засаг даргын Тамгын газрын 31 албан хаагчдад сургалт зохион байгуулж, Авлигын эсрэг хуулиар “Алтан хонх” тэмцээн зохион байгуулж ажиллалаа.

Сумын баяр наадмын арга хэмжээнд суманд үйл ажиллагаа явуулж байгаа төр төсвийн 15 байгууллага, 8 холбоод хамтран оролцож нээлтийн үйл ажиллагаанд байгууллага тус бүр парад алхалтаар оролцон, сумын хүндэт 4 иргэн тугаа мандуулснаар сумын баяр наадмыг нээлтийн үйл ажиллагаа эхэлж, 64 бөхийн барилдаан, өсвөрийн хүүхдийн бөхийн барилдаан, 6 насны морины уралдаан, ахмадын соф волейбол, өсвөрийн сагсан бөмбөгийн тэмцээн эрэгтэй эмэгтэй, өсвөрийн холимог волейболын тэмцээн, дээлтэй Монгол гэр бүл шалгаруулах тэмцээнүүдийг тус тус амжилттай зохион байгуулан ажиллалаа.

Үндэсний их баяр, наадмын өдрүүдэд ард иргэдэд шаардлагатай эмнэлгийн тусламжийг цаг алдалгүй чанартай, хариуцлагатай үзүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний тасралтгүй, бэлэн байдлыг хангах, эрсдэлээс сэргийлэх, хяналт тавихтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах зорилгоор 2022 оны 07 сарын 10-16-ны өдрийг дуустал хугацаанд өдрийн 2 ээлжээр нийт 14 мэргэжилтнийг хариуцлагатай жижүүрээр томилон ажиллуулсан бөгөөд энэхүү хугацаанд эмнэлгийн тусламж үйлчилгээнд ямар нэгэн доголдол гараагүй, хариуцлагатай жижүүрүүд болон ээлжийн ажилчид хуваарьт цаг хугацаандаа зөрчил дутагдалгүй, хариуцлагатай ажиллаж мэдээ, мэдээллийг тухай бүрд нь гарган холбогдох газруудад мэдээлж нийт үзлэг-1326, урьдчилан сэргийлэх үзлэг-230, өвчний учир амбулаторид үзүүлсэн-373, идэвхтэй хяналт-421, Гэрийн үзлэг-302 тус тус зохион байгуулан ажиллалаа.

Үерт өртөж болзошгүй айл өрхүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, сумын хэмжээнд 3 хэсэгт 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг томилон эрсдэлтэй бүс нутагт суурьшихгүй байх, нүүлгэн шилжүүлэх, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх талаар анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээллийг иргэдэд хүргэж ажиллав.

Номгон 3-р багийн нутаг дэвсгэрт байрлах үерт өртсөн 9 айл өрхийн 27 иргэнийг Гал түймэр унтраах, аврах 61 дүгээр ангийн бие бүрэлдэхүүнтэй хамтран нүүлгэн шилжүүлэн ажиллав. Уг нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд сумын ЗДТГазрын 6, Номгон 3-р багийн Захирагчийн албаны 8 Гал түймэр унтраах, аврах 61 дүгээр ангийн 10 албан хаагч, нийт 18 албан хаагч нүүлгэн шилжүүлэх ажиллагаанд дайчлагдан ажиллав.

Мөн үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх анхааруулга бүхий санамж сэрэмжлүүлэг хуудас /боршур/ 250 ширхгийг иргэдэд тараан, мэдээлэл өгч, сумын

цахим хуудсаар сэрэмжлүүлэг, мэдээ мэдээллийг иргэдэд тогтмол хүргэн ажилласан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Жимстэй хорооллын "Үерийн далан сэргээн засварлах" ажлыг олон нийтийн оролцоотой иргэдийн бүлгээр гүйцэтгүүлэн, хүлээн авсан болно.

Уг ажлын хүрээнд:

- 600*6 метр харьцаатай зам түрж тэгшлэх ажил,
- Үерийн даланг нөхөн сэргээж засварлах ажил,
- 2 ширхэг нүхэн гүүртэй гарц хийх ажлуудыг тус тус хийж гүйцэтгүүлсэн болно.

Сүхбаатар сум:

Бүгд Найрамдах Солонгос Улсын Сувилахуйн ухааны сургуулийн эмч, оюутнууд 7 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд Партизаны талбайд дотор, шүд, хүүхдийн эрүүл ахуй үзлэг эмчилгээ хийж, нүүр будалт, үс засалт, сувилахуйн ухааны сургалт зохион байгуулж иргэдийг нээлттэй хамрууллаа.

Сүхбаатар сумын "Ахмадын явган аялал"-ын тэмцээнийг 7 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан. Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллагатай хамтран 7 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд "Санхүүгийн төлөвлөлт, төсөл бичиж хэрэгжүүлэх суурь ойлголт" сургалтыг зохион байгуулж, 8 багийн ажилгүй, өрх толгойлсон 27 иргэнийг хамруулсан.

УИХ-ын гишүүн Д.Өнөрболор Хонгорморьт 1 дүгээр багийн Хужир нуга хэсгийн малчдад гол гатлах моторт завь хүлээн хүлээлгэн өгсөн.

Сайханы хөтөл чиглэлд аялж, зугаалж буй дотоод гадаадын аялагчдын Хонгорморьт 1 дүгээр багийн зам дагуу үүсгэсэн хог хаягдлыг багийн иргэдийн оролцоотой цэвэрлэх ажлыг зохион байгуулж, нийт 7 тонн хог хаягдлыг төвлөрүүлэн хогийн цэг рүү хаяж, зам дагуу санамж байршуулсан.

Аймгийн Онцгой комиссын 2023 оны 02 тоот албан даалгаврын дагуу Сүхбаатар сумын Онцгой комиссоос "Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллах тухай" 2023 оны 01 тоот албан даалгавар, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллах төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажилласан.

Голын эрэг дагуу оршин суудаг үер усны аюулд өртөж болзошгүй, өндөр эрсдэлтэй айл өрхүүдийн судалгааг гаргахад 40 айл өрх байсан. Орхон голын цаана зусдаг 1-р багийн 7-н өрхийн 30 гаруй иргэн, 1800 хонь ямаа, 112 адуу, 270 үхрийг аймгийн Онцгой байдлын газрын аврах ангитай хамтран нүүлгэн шилжүүлсэн.

Мөн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газраас түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагааны нийтийг хамарсан ажлын хүрээнд 8-н багийн 30 иргэнийг түр ажлын байраар ханган үерийн далан, гуу жалга, нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэж нийт 8тн орчим хог хаягдлыг цэвэрлэсэн.

Баян хан 4 багийн хэсэгт байрлах "Гурвалжин"-гийн хэсэгт борооны тогтоол ус тогтож машины зорчих хэсэгт хүндрэл үүссэн байсныг шуудуу гарган усыг урсгаж, шороог засварлаж янзалж аюулгүй болгосон.

Үерийн усны аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор Баян хан 4-р багийн 4-р хэсэг Дэнжид дулааны шугам руу ус орох эрсдэлтэй цэгт "Сэлэнгэ Энерго" ОНӨААТҮГ-ын техникийн тусламжтайгаар хамгаалалтын далан хийх, Орхон 6 дугаар баг, Салхит 3 дугаар багийн 2, 3, 4 дүгээр хэсгүүдийн үерийн даланг сэргээн засварлах ажлуудыг хийлээ.

Аймгийн Онцгой комиссын 2023 оны 02 тоот албан даалгавар, Сүхбаатар сумын Онцгой комиссын 01 тоот албан даалгаврын үүрэг чиглэлийн дагуу малчид болон иргэдэд үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг үерт өртөх өндөр эрсдэл бүхий 40 өрхөд бичгээр хүргэж, цахим хаягаар мэдээлэн,

Орхон голын эрэг, Буурын голын эрэг, Бойны тохойн эрэг дагуу үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээний хүрээнд мэдээллийн 10 жижиг 1 том самбарыг байршуулан ажилласан.

Мөн бүх нийтийн амралт болон аялал жуулчлалын улирал эхэлсэнтэй холбогдуулан байнгын бэлэн байдалд хяналт тавьж голын эрэг дагуу амарч буй нийт 637 буюу 344 том хүн, 293 хүүхдэд үер усны аюулаас урьдчилан сэргийлэх 297 ширхэг албан мэдэгдэл, зөвлөмж өгч ажилласан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийх ажлын саналыг 8-н багийн иргэнээс авч эрэмбэлэн, иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлсэн.

Түшиг сум:

“ММЭ Түшиг” ХХК-ийн Улаалзганатын аманд нарс 200 м³ хэрэглээ, 70 м³ түлээ бэлтгэл, “Мойлт нуга” ХХК буйлаастын аманд 160 м³ нарс мод бэлтгэл, УБТЗ-ын мод бэлтгэлийн үйлдвэрийн мод бэлтгэлд хяналт тавьж, орон нутгийн иргэдэд 130 м³ хэрэглээний мод худалдан борлуулах үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавин ажиллалаа.

УБТЗ мод бэлтгэлийн үйлдвэрийн бэлтгэсэн модыг орон нутгийн 35 өндөр настан, зорилтот бүлгийн айл өрхөд өгсөн. Гацуурт ХХК-ийн үйл ажиллагаатай холбоотой гаргасан гомдол, мэдээллийн дагуу Гацуурт ХХК-ийн эрчимсэн мал аж ахуйн бүс, Тариалангийн талбайд 3 хоногийн хугацаанд хэмжилт, зураг авалт хийн ажилласан байна.

Хушаат сум:

7 сарын байдлаар улаанбуудай 12564 га, тэжээлийн ургамал 491 га, овьёос 207 га, тосны ургамал 3744 га, төмс 200,25 га, хүнсний ногоо 323,63 га талбайд тариалалт хийгдсэн байна.

Мал төлөлт: унага 882, тугал 3837, хурга 18747, ишиг 13679, нийт 37145 төл бойжиж байна. Зүй бус хорогдол: адуу 56, үхэр 212, хонь 435, ямаа 487, нийт 1190 толгой мал байна.

7 дугаар сарын 17-ны өдөр Хушаат сумын Арсүүжийн чиглэлд орсон хүчтэй мөндрийн улмаас 2 аж ахуйн нэгжийн нийт 504 га талбайд тариалсан улаанбуудай, 199 га талбайд тариалсан рапс мөндөрт цохигдож 100% ургац алдсан. Мөн 9 өрхийн 20 бог хоригдож, 5 автомашины салхины шил хагарч, гэрийн бүрээс урагдаж, 1 хүүхдийн толгой хагарч гэмтэж акт тогтоон аймгийн Онцгой байдлын газарт мэдээллийг хүргүүлсэн.

Мөн их хэмжээний үргэлжилсэн бороо орж Орхон голын усны түвшин нэмэгдэж үерийн аюултай түвшин хүрч сумын Онцгой комиссын Шуурхай штабаас үерийн уснаас 80 бодыг үерийн уснаас гаргах, 3 өрхийг нүүлгэх арга хэмжээг шуурхай авч ажилласан.

Сумын төвийн хог хаягдлын цэгийн тархалтыг багасгах, цэвэрлэх, түрж дотогшлуулах ажлыг 3 удаа зохион байгуулан нийт 3 тээврийн хэрэгсэл, 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр 8 тн хог хаягдлыг цэвэрлэж, хогийн цэгийн тархалтыг 1 га талбайгаар багасгаж ажилласан.

Мөнхтолгой багийн Хуучин төвийн Цагаан овооны тахилга наадмыг угтаж Цагаан овооны ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэж, булж устгах ажлыг зохион байгуулан 2 тээврийн хэрэгсэл, 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр 20 тн хог хаягдлыг цэвэрлэж, мөн зам давааны хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулан 2 тн хог хаягдлыг цэвэрлэж хог хаягдлын цэгт ачиж, булж устгалаа.

7 дугаар сарын байдлаар ойн нөөцийн орлогод 284,2 м³ мод бэлтгэж 3,437,990 төгрөгийг төрийн санд төвлөрүүлсэн байна. Хууль бус загасчлалаас урьдчилан сэргийлэх зорилгоор Орхон, Сэлэнгэ голын эрэг дагуу 2 удаа хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 12 тээврийн хэрэгсэл, 48 иргэнд зөвлөмж, мэдээлэл хүргүүлэн ажиллалаа. Мөн амралт зугаалгаар явж буй иргэдэд хог

хаягдал хаяхгүй байх, галын аюулгүй байдлыг хангаж ажиллах талаар зөвлөмж мэдээллийг 86 иргэнд өгч ажилласан.

Хүдэр сум:

Мал эмнэлгийн нэгдсэн санд тайлант сард 33 удаагийн гэрчилгээг цахимаар баталгаажуулж, иргэдэд хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэн ажиллаа. Үүнд: Адуу 15 толгой, үхэр 20 толгой, хонь 140 толгой, ямаа 80 толгой, адууны мах 100 кг, үхрийн мах 350 кг, хонины мах 18кг, 468 кг, тус бүр эрүүл мэндийн гэрчилгээ олгож хяналт тавин ажилласан.

Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд "Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх төлөвлөгөө болон Хүдэр сумын ИТХ-ын 2018 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн 90 тоот тогтоолоор батлагдсан "Хог хаягдал үүсгэсний хураамж авах" журмын дагуу өөр аймаг, нийслэл сумдаас аялах, амарч зугаалах, байгалийн дагалдах баялаг жимс жимсгэнэ, ургамал түүх, хадлан тэжээл бэлтгэх болон бусад зорилгоор ирж буй иргэдээс хог хаягдал үүсгэсний төлбөр хураамжийг 1000 төгрөгөөр тооцож авсан. Үүссэн хог хаягдлыг Хүдэр тохижилт ОНӨААҮТГ-тай хамтран сумын Баянцагаан 2-р багийн нутаг дэвсгэр болох Мухар хөндий, Жалга, Уялга чиглэлд явж иргэдийн үүсгэсэн ахуйн хог хаягдлыг зөөн тээвэрлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

Хүрээлэн буй орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт шалгалтыг хийж Баянцагаан 2-р багийн нутаг дэвсгэр болох Цагаан Зүрийн гол дагуу зохих зөвшөөрөлгүй хууль бусаар техник хүн хүчээ төвлөрүүлсэн 8 иргэнийг бүртгэлжүүлэн техник хэрэгслээ татан буулгах тухай албан мэдэгдэл өгсөн.

Байгаль орчин аялал жуулчлалын яамны албан тоотын дагуу хуш модны самрын цэцэглэлтийн үеийн судалгааг амж нэртэй газарт Оросын Холбооны Улсын эрдэмтэн В.Г.Капперийн аргаар гаргаж үзэхэд сайн ургацтай буюу ганц нэгээрээ болон ойн захад ургасан модонд боргоцой, үр, үр жимс арвин, дундаж болон болц гүйцсэн насны ойд хангалттай сайн ургацтай байна гэсэн дүгнэлт гарсан.

Ойн ангийн мод үржүүлгийн газрын 15 плантацын хогийн ургамал цэвэрлэх ажилд тус сумын ажилгүй 8 иргэнийг түр ажлын байраар хангаж ажиллуулсан байна.

Хурдан морины зургаан насны уралдаан зохион байгуулагдаж Их нас-48, Азарга-13, Хязаалан-21, Соёолон-17, Шүдлэн-12, Даага-24 нийт зургаан насны 135 морь, давхардсан тоогоор 30 унаач хүүхэд уралдсан. Уралдааны үед Хязаалан насны мориноос нэг хүүхэд унасан, бэртэл гэмтэл аваагүй. Үндэсний морин уралдааны уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS6264:2018 стандартын хэрэгжилтийг хангаж, гэнэтийн ослын даатгалд хамрагдсан, эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөл авсан тал дээр хяналт тавьж цаасан бүртгэл хийж ажилласан.

Сумын Эрүүл мэндийн төвд эмчийн үзлэг 234 хийгдсэнээс 61 буюу 29 % хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 125 буюу 53.4 хувийг өвчний учир амбулаторт, 37 буюу 15.8 хувийг идэвхтэй хяналтын үзлэг, 11 буюу 4.7 хувийг гэрийн үзлэг эзэлж байна.

Амбулаторийн үзлэгийн 34.6 хувийг их эмч, 33.7 хувийг эх баригч, 31.7 хувийг бага эмч үзлэг хийж оношилгоо эмчилгээг шийдвэрлэсэн байна.

Хэвтүүлэн эмчлэх тасагт 31 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлж 219 ор хоног ашигласан байна. Жирэмсний хяналтад 3 эх шинээр эхний 3 сартайд орж жирэмсний эрт үеийн хяналт 100% байна.

Шаамар сум:

7 дугаар сарын 07-09 ний өдрүүдэд болсон үерийн улмаас Дулаанхаан тосгоны 62 дугаар гарам, Охиндийн 2-р багийн төв болон Нарсан сүүл үерт бүрэн автсан. Үерийн гамшгаар 39 хашаа байшин, 22 гэр үерт автсан. Хүний амь нас

эрүүл мэнд хохироогүй. Хүнсний ногооны 182 га талбай үерт орж, төв замын 42м² хэсэг эвдэрснийг “Монголзам ЛЗ” ХХК засаж сэргээсэн.

Дулаанхаан 62-р гарамын сэтэрсэн даланг аймгийн Онцгой байдлын газрын албан хаагчид болон хувийн хэвшил, тосгоны Захирагчийн ажлын алба хамтран засаж өндөрлөсөн.

Үерийн гамшгийн үеэр сумын Онцгой комисс, төрийн албан хаагч нийт 60 хүн ажиллаж үерийн бүсээс иргэдийг нүүлгэн шилжүүлэх, үерт өртсөн айл өрхийн иргэдийг түр байрлуулах байранд хүргэх, аюулын зарлан мэдээлэх, сэрэмжлүүлэг хүргэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв.

Сумын 8-н хүнсний дэлгүүрүүдээр малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд хүнсний аюулгүй байдалд хяналт шалгалт хийж гарсан зөрчлийг тухай бүрд нь арилгуулж 2 удаа ажилласан.

Малын гоц халдварт А/01 өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг цаг тухай бүрд нь эхэлж вакцинжуулалтын ажил дуусаж байна.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР